



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ




Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • IV • № 31



Н.БАТСАЙХАН:
БАНК БҮР ДЭЭР
ГАЗАР ДЭЭРХ
ИЖ БҮРЭН
ШАЛГАЛТЫГ
ХИЙДЭГ

ТӨВ БАНКНЫ
ХАРААТ БУС
БАЙХ НЬ ҮНИЙН
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЧУХАЛ
ХҮЧИН ЗҮЙЛ



Зургийн тайлбар: Яармаг дахь үзэсгэлэн худалдаанд байрлуулсан
Худалдаа аж үйлдвэрийн банкны асар



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn



Хөгжилд түргээлсэн
95 жил

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан шинэ захирлыг хүлээн авч уулзав

4

Ярилцлага:

ХУУДАС

Банк бүр дээр газар дээрх иж бүрэн шалгалтыг хийдэг

6

Байр суурь:

ХУУДАС

Капитал банкнийг татан буулгасан талаар хэн, юу хэлэв?

10

Нийтлэл:

ХУУДАС

Капитал банк ХХК-д авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

12

Монголбанкны**Эрдэнэсийн сангаас**

ХУУДАС

Сайн малчны өргөмжлөл

14

Нийтлэл:

ХУУДАС

Төв банкны хараат бус байх нь үнийн тогтвортой байдлын чухал хүчин зүйл

15

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас (2019.04.26)

22

Банкир:

ХУУДАС

Жяан Паскал Нганоу: Эдийн засагт санхүүгийн системийн тогтвортой байдал хамгаас чухал

27

Банкны хөгжил-95**жил:**

ХУУДАС

Санхүү, мөнгөний бодлогын шинэ үе

30

Судалгаа:

ХУУДАС

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд хиймэл оюун ухааны үзүүлж буй нөлөө

32

Дэлхийн үйл явдал:

ХУУДАС

Дэлхийн дампуурсан банкуудын түүх

35

Санхүүгийн боловсрол:

ХУУДАС

Банкаа хэрхэн зөв сонгох вэ?

37

Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан шинэ захирлыг хүлээн авч уулзав

2019.04.04

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан Дэлхийн Банкны Хятад, Монгол, Солонгос улсыг хариуцан ажиллахаар томилогдсон Мартин Рейзерийг албаны хүмүүсийн хамт хүлээн авч уулзлаа. Уулзалтаар Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй бодлогын шийдвэр, Монгол Улсын эдийн засгийн сэргэлтэд оруулсан хувь нэмрийн талаар мэдээлэл солилцож, тогтвортой байдлын төлөө цаашид хийж, хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцлоо. Түүнчлэн Монгол Улсад хэрэгжиж байгаа Дэлхийн банкны “Эдийн засгийн удирдлагыг дэмжих хөгжлийн бодлогын хөтөлбөр” болон Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хэрэгжилт, эдийн засагт гарч байгаа эерэг өөрчлөлтүүдийн талаар ярилцсан юм.



“Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны нээлт болов

2019.04.08



Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг 3 дахь жилдээ зохион байгуулахаар аяны нээлтийг хийлээ. Зургаан сарын хугацаанд үргэлжлэх уг аяны нээлтэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын Ерөнхий Газар, арилжааны банк болоод алт үйлдвэрлэгч иргэд, аж ахуйн нэгж оролцсон юм. Энэ үеэр алтны худалдан авалтыг нэмэгдүүлэх, хууль журмыг сурталчлах талаар мэдээлэл солилцлоо. Мөн аяны хүрээнд алтны гарал үүслийг тодорхой болгох, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх явдлыг таслан зогсоох, алт олборлогч, худалдан авагчийн нэгдсэн платформ, програм хангамжийг Ашигт малтмал, газрын тосны газар болон бусад холбогдох төрийн байгууллагуудтай хамтран судалж, бий болгохоор ажиллана гэдгээ талууд мэдэгдлээ.

“Капитал” банкны татан буулгах шийдвэр гаргав

2019.04.08

Монголбанкнаас Төв банк (Монголбанк), Банкны тухай хуулийн дагуу “Капитал банк” ХХК-д зохих арга хэмжээг авсан хэдий ч биелэлт хангагдахгүй, улмаар хадгаламж эзэмшигч, харилцагч болон мөнгөн төлбөрийн шаардах эрх бүхий этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй, банк хоорондын төлбөр тооцооны гүйлгээг саатуулж, банкны заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж чадахгүйд хүрч, тус банк цаашид хэвийн үйл ажиллагаа эрхлэх чадваргүй болсон тул Монголбанкнаас 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр тус банкныг албадан татан буулгах шийдвэр гаргав.



Активын удирдлагын тухай хуулийн төслийг хэлэлцэв

2019.04.16

Эдийн засгийн мөчлөг дагасан чанаргүй зээлийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Активын удирдлагын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр санаачилж, хуулийн хэлэлцүүлгийг Монголбанктай хамтран зохион байгуулав. Активын удирдлагын тухай хуулийн төсөл батлагдсанаар зах зээл дэх зээлийн нийлүүлэлт нэмэгдэж, бизнес эрхлэгчдэд эдийн засгийн бодит дэмжлэг хүрэх, зээлийн эргэн төлөлтийн явц хурдасч, чанаргүй активыг удирдах, хөрвөх чадвартай хоёрдогч захын үйл ажиллагаа хөгжих, чанаргүй зээлийг шийдвэрлэх замаар зээлийн хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг нийгэм, эдийн засаг, эрх зүйн эерэг үр дагавар бий болно гэж хууль санаачлагчийн зүгээс үзэж байна.



“Монголбанкнаас боловсруулдаг статистик нь ОУВС-гийн “Мэдээлэл тархаалтын тусгай стандарт”-д шилжлээ

2019.04.17



Монгол Улс Олон Улсын Валютын Сан (ОУВС)-аас боловсруулан гаргасан статистик мэдээлэл тархаах дэлхийн жишиг загвар болж буй “Мэдээлэл тархаалтын тусгай стандарт”-д 2019 оны 4 дүгээр сарын 2-ны өдрөөс шилжээд байна. ОУВС нь өөрийн гишүүн орнуудын статистик мэдээлэл тархаах стандартыг тодорхойлж, түүнийг тогтмол сайжруулдаг. Гишүүн орнууд нь статистик мэдээллээ нийтэд тархаах эхний алхмаа “Мэдээлэл тархаалтын ерөнхий систем” (GDDS)-ээр эхлүүлж, улмаар “Мэдээлэл тархаалтын тусгай стандарт” (SDDS)-д шилжсээр байна. “Мэдээлэл тархаалтын тусгай стандарт” нь статистик мэдээллээ стандартчилагдсан тодорхойлолт, давтамж, хэлбэрийн дагуу олон нийтэд зайлшгүй зарлах шаардлагыг тавьдаг байна.

“Эдийн засгийн бодлогын чуулган-2019”-г амжилттай зохион байгууллаа

2019.04.19

Энэ удаагийн чуулганаар “Банкны хөгжил-95 жил”, “Санхүүгийн салбарын дархлааг бэхжүүлэх нь”, “Финтек: Санхүүгийн зах зээлийн ирээдүй” хэмээх гурван гол сэдвийн хүрээнд илтгэл танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүллээ. Уг чуулганд УИХ, Монголбанк, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Үндэсний хөгжлийн газар, Хөгжлийн банк, арилжааны банкууд болон Олон Улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн 100 гаруй төлөөлөгч оролцож, Монгол Улсын банк санхүүгийн салбарын түүхэн хөгжлийн явц дахь ололт, сургамжийн тухай мөн онцолж, байр сууриа илэрхийлцгээсэн юм.



“Чанаргүй зээл түүний эрх зүйн орчин” сэдэвт хэлэлцүүлэг болов

2019.04.22



Монголбанкнаас санаачлан хууль зүйн болон төсөв санхүүгийн бодлого хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хууль, шүүхийн байгууллага, тус салбарын мэргэжлийн сургалт судалгааны байгууллага, мэргэжлийн холбоо, Олон Улсын байгууллагын төлөөлөл оролцсон “Чанаргүй зээл түүний эрх зүйн орчин” сэдэвт хэлэлцүүлэг Төрийн ордонд боллоо. Чанаргүй зээлийг шийдвэрлэх нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөхийн зэрэгцээ санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэн зөв, ил тод болгож, хуримтлал, хөрөнгө оруулалт бий болгох замаар баялгийг бүтээх, хөгжлийг бий болгох, бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг мөнгө, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах чухал ач холбогдолтой гэж хэлэлцүүлэгт оролцогчид дүгнэлээ.



БАНК БҮР ДЭЭР ГАЗАР ДЭЭРХ ИЖ БҮРЭН ШАЛГАЛТЫГ ХИЙДЭГ

Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Н.Батсайхантай банкны хөгжлийн тогтвортой байдлын талаар ярилцлаа.

МОНГОЛБАНКНААС БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫГ БЭХЖҮҮЛЖ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ, ШИНЭЧЛЭЛИЙН ЯВЦЫН ТАЛААР ТОДОРХОЙ МЭДЭЭЛЭЛ ӨГНӨ ҮҮ?

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу 2017 оны 5 дугаар сараас эхлэн манай улсад ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжиж байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны санаачилгаар ОУВС-ийн техник туслалцааны дэмжлэгтэйгээр банкны системд томоохон эерэг өөрчлөлтүүд хийж эхэлсэн. Банкны салбарын эрх зүйн зохицуулалт, Монголбанкнаас банкинд хяналт тавих үйл ажиллагааны хууль эрх зүйн орчныг олон улсын зарчим, хэм хэмжээнд тулгуурлан боловсронгуй болгох бодлого баримталж, хэрэгжүүлэхээр болсон. Иймд, Төв банк, Банкны тухай хууль, холбогдох хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг УИХ-аар батлуулснаар банкны системийн

найджартай байдлыг илүү бэхжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Мөн банкнуудад активын чанарын үнэлгээг хийснээр банкны салбарын эмзэг байдлыг тодорхойлж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор банкуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Учир нь чанаргүй зээл нь банкны актив хөрөнгийг бууруулах, банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийг хорогдуулж, зээлийн хүүгийн түвшинг өндөр байлгах сөрөг үр дагавартай төдийгүй банкны тогтолцооны төлбөрийн чадварт шууд нөлөөлдөг тул чанаргүй зээлийг бууруулах стратеги, төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР БАНКНЫ САЛБАРЫН САХИЛГЫГ УЛАМ ЧАНГАТГАНА ГЭЖ ОЙЛГОЖ БОЛОХ УУ. ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ,

ХАРИЛЦАГЧИЙГ ХОХИРООХООС ӨМНӨ АРГА ХЭМЖЭЭГЭЭ АВААД ЯВАХ УУ? САЯ ШИНЭЧЛЭГДСЭН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ЭНЭ СТАНДАРТАД НИЙЦҮҮЛСЭН ҮҮ?

Монгол Улсын банкны системийн суурь хууль болох Банкны тухай хуулийг 2018 оны 1 дүгээр сард шинэчлэн баталж, 4 дүгээр сараас эхлэн мөрдөж эхэлсэн. Хуучин мөрдөж байсан хуулийн ерөнхий үзэл баримтлал нь “гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтын”-ын зарчимд тулгуурласан байсан нь хянан зохицуулагч байгууллагын зүгээс банкны үйл ажиллагааны эрсдэлд тохируулан урьдчилан сэргийлэх, зохицуулах арга хэмжээ авах, Монголбанкнаас авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээг авах эрх зүйн үндэслэлийг банкны бизнес төлөвлөгөө, эрсдэлийн сорил, хяналт шалгалтын дүнд үндэслэхгүй зөвхөн өөрийн хөрөнгийн үзүүлэлтийн түвшнээс хамаарч авах зэрэг дутагдлууд

байсан. Иймд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчмыг хэрэгжүүлж эхлэх зорилгоор Банкны тухай хуульд урьдчилан сэргийлэх чиглэлийн бүхий л арга хэмжээний талаар тусгасан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэдэг маань банкны тухай хууль тогтоомжийг зөрчихөөс өмнө буюу тухайн банкны эрсдэлд үндэслэн банкинд тохирсон арга хэмжээ авахыг хэлж байгаа юм. Ингэснээр банкны системийн найдвартай байдлыг бэхжүүлэх, түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мөн таны хэлснээр банкны салбарын сахилгыг чангатгах боломжтой юм.

БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ГЭДЭГ НЬ БАНКИЙГ ТАТАН БУУЛГАХ ХЭМЖЭЭНД ХҮРГЭХГҮЙН ТӨЛӨӨ ЗОРЬДОГ ГЭЖ ОЙЛГОЖ БОЛОХ УУ?

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд зааснаар Монголбанк банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авах, дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг. Монголбанк энэ чиг үүргээ банкуудад зайнаас хяналт тавих болон газар дээр нь очиж шалгах хэлбэрээр хэрэгжүүлж байна. Банк болгонд газар дээрх иж бүрэн хяналт шалгалтыг банкны үйл ажиллагаа, удирдлага, санхүүгийн чиглэлээр

баримт материал шалган танилцах байдлаар хийгддэг, шаардлагатай тохиолдолд банкуудад хэсэгчилсэн хяналт шалгалтыг хийдэг. Харин зайны хяналтыг банкнаас мэдээлэл хүлээн авч хянах байдлаар тогтмол хийдэг гэсэн үг юм.

КАПИТАЛ БАНКИЙГ ТАТАН БУУЛГАСАН НЬ БАНКНЫ САЛБАРЫН ЭРҮҮЛ МЭНД ХЭВИЙН БАЙГАА ГЭСЭН МОНГОЛБАНКНЫ МЭДЭГДЭЛТЭЙ ХЭР НИЙЦСЭН АРГА ХЭМЖЭЭ ВЭ?

Банкны салбарыг бэхжүүлэх талаар баримталж байгаа бодлого, ОУВС-ийн хөтөлбөр бүхэлдээ банкны салбарын "эрүүл мэнд"-ийг тодорхойлж, гарсан доголдол, асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарал хандуулсаар ирсэн. Ийм ч учраас Монголбанк активын чанарын үнэлгээг хийж, банкуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх тал дээр дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн билээ. Энэ оны 3 дугаар сарын байдлаар системийн хэмжээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 41.4 хувь байна. Өөрөөр хэлбэл, банкууд бусдаас нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 41.4 хувийг түргэн борлогдох, хөрвөх чадвар сайтай актив хөрөнгөнд байршуулсан байгаа нь сайн үзүүлэлт юм.

Капитал банк системийн нөлөө бүхий банк биш учир банкны салбарын санхүүгийн үзүүлэлтүүдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж дүгнэсэн бөгөөд өнөөдрийн байдлаар бусад банкны үйл ажиллагаанд ямарваа нэгэн сөрөг үр дагавар гараагүй байна.

Монголбанкны мэдэгдэл бол бүх банкны үзүүлэлтийг нэгтгэсэн дүгнэлт бөгөөд зарим банкны хувьд өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг Монголбанкнаас тухай бүр мэдэгдэж байсан.

ТАТАН БУУЛГАХ ТУХАЙД СОНИРХОХОД, ЯАГААД ӨМНӨ НЬ БИДЭНД МЭДЭГДЭЭГҮЙ, МОНГОЛБАНКНААС ЯАГААД АРГА ХЭМЖЭЭ АВААГҮЙ ВЭ? ГЭДЭГ ГОМДЛЫГ БАНКНЫ ХАРИЛЦАГЧИД ТАВЬЖ БАЙГАА. ШИЙДВЭР ЗАРЛАХТАЙ ХОЛБООТОЙ ТАЙЛБАРЫГ ЭНЭ ДАШРАМД ӨГНӨ ҮҮ?

Банкны тухай хуульд зааснаар Монголбанк банкнийг албадан татан буулгах шийдвэр гаргасны дараа нэн даруй олон нийтэд мэдэгдэх үүрэгтэй байдаг. Монголбанк Капитал банкнийг албадан татан буулгах шийдвэрийг гаргах явцад банк, түүний удирдлагуудад Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан, гарсан шийдвэрийг тэр өдөртөө багтаан хэвлэлийн бага хурал зарлаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдсэн. Өөрөөр хэлбэл, татан буулгах шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажиллагаа маань хуулийн хүрээнд л явагдсан.

Харин Капитал банкнийг албадан татан буулгахаас өмнөх арга хэмжээ Монголбанк хуульд заасан шаардлага тавих, хугацаатай үүрэг даалгавар өгөх, үйл ажиллагааг хязгаарлах, төлөөлөгч, хянагч томилох зэрэг хуульд заасан арга

хэмжээг банкны нөхцөл байдалд тохируулан авч байсан. Банкны тухай хуульд заасан шаардлага, хязгаарлалтыг хангаагүй, Зөрчлийн тухай хуульд зааснаар зөрчлийн хэрэг үүсгэж торгууль ногдуулах гэх зэрэг арга хэмжээ ч үүнд багтана.

Энд онцлох дурдах нэг асуудал нь банкнаас олгосон зээлийн чанар муудаж, зээлдэгч зээлсэн мөнгөө эргүүлэн төлж чадахгүй болсноос банк төлбөрийн чадваргүй болж байгааг ойлгох нь чухал. Хэнд зээлээ олгох нь тухайн банкны дотоод асуудал, Монголбанк үүнд оролцох эрхгүй. Харин олгож болох зээлийн хэмжээнд хууль, журмаар тавьсан шаардлагыг нь мөрдүүлж, зээлийн чанар муудвал зөв ангилуулж, эрсдэлийн сан байгуулуулах нь Монголбанкны үүрэг байдаг. Монголбанкны хяналт шалгалтаар Капитал банкны удирдлага зээлээ буруу ангилсан, эрсдэлийн сангаа дутуу байгуулсан, харилцагчийн мөнгийг гаргаж өгөх чадвар алдагдсан учраас төлбөрийн чадваргүйд тооцож татан буулгасан. Монголбанкны эрх хүлээн авагч банкны олгосон зээлийг төлүүлж, мөнгөн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлж, хадгаламж эзэмшигчийн өмнө банкны хүлээсэн төлбөрийн үүргийг ханган ажиллана.

БАНК ТАТАН БУУГДАХЫГ БУСАД УЛС ОРНЫ ХУВЬД ХЭР НОЦТОЙ АСУУДАЛ ГЭЖ ҮЗДЭГ ВЭ?

АНУ-ын Хадгаламжийн даатгалын корпорацийн статистик мэдээллээс харахад 2001-2019 онд нийт 553 банк татан буугдсан байна. Санхүүгийн хямралын үеэр буюу 2009, 2010 онд гэхэд л 297 банк “хаалгаа барьсан”. Харин ОХУ 2015 оноос буюу хойш буюу 4 жилийн дотор 293 банкны зөвшөөрлийг хүчингүй болгон албадан татан буулгасан байна. Харин манай Монгол Улсын хувьд гэвэл хоёр шатлалт банкны систем бий болсноос хойш 14 банк дампуурсан байдаг.

Банкийг татан буулгах үндэслэл, нөхцөлийг улс болгоны банкны хууль тогтоомжид тодорхой заасан байдаг, манай улсын хувьд ч ялгаагүй, Банкны тухай хуульд албадан татан буулгах үндэслэлийг тодорхой заасан байгаа.

ЕР НЬ ЭЦЭСТ НЬ СОНИРХОХОД МАНАЙ УЛСАД ДЭНДҮҮ ОЛОН БАНК БАЙНА ГЭЖ ҮЗЭХ НЬ БИЙ. ХЭРЭВ ТИЙМ БОЛ ЖИЖИГ

БАНКУУДАА НЭГТГЭЖ, НИЙТЭД НЬ СИСТЕМИЙН НӨЛӨӨ БҮХИЙ БАНК БОЛГОЖ БАНКИНД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ УЛАМ БЭХЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ БИШ ҮҮ ГЭСЭН АСУУДАЛД ТА ЯМАР БАЙР СУУРИНААС ХАНДАХ ВЭ.

Зарим эдийн засагч, судлаачид манай улсыг банкны зах зээлийн “хүчин чадал”-саа илүү гарсан тооны банктай гэж үздэг. Өөрөөр хэлбэл, нийгэмд үр өгөөж авчрах хамгийн оновчтой тооны банктай байх нь зохистой. Банкуудын тоо байх ёстой зохистой тооноос хэтэрвэл тэр банк нь өөрөө “нийгмийн зардал” болох сөрөг үр дагавартай. Монголбанк банкуудын санхүүгийн чадавхийг сайжруулах зорилгоор банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2021 оны эцэс гэхэд 100 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэх үүрэг даалгавар өгч, шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. Гэхдээ жижиг банкууд сайн дураараа нэгдэх нь банкуудын хувьцаа эзэмшигчдийн хүсэл зоригоос хамаарна.

КАПИТАЛ БАНК ХХК-Д АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

2015.10
Капитал банкны үйл ажиллагаа доголдож эхэлснээр шат дараатай арга хэмжээг авч эхлэв.

Капитал банкны зөрчил дутагдлыг арилгах, банкны засаглалыг сайжруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэв.

Банкны салбарын активын чанарын иж бүрэн үнэлгээний хүрээнд хийгдсэн ажлууд

2017.02
Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг ажлын хэсгийн түвшинд тохиролцов.

2017.05
Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг батлав.

2017.08
Арилжааны бүх банкинд активын чанарын үнэлгээг хийж эхлэв.

2018.02
Активын чанарын үнэлгээний үр дүнг мэдээлэв.

2018.03
Монголбанкнаас өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх 9 сарын хугацаатай үүрэг даалгаврыг өөрийн хөрөнгийн дутагдалтай банкуудад өгөв.

2018.12
Капитал банк өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх эцсийн хугацаа дуусав.

Капитал банкыг татан буулгав

Банкны тухай хуулийн дагуу Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авах үндэслэлгүй байв.

Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв

48.1.1. Зөрчил, дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх;

48.1.2. Зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

48.1.3. Тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтоосон түвшинд хүргэхийг даалгах;

48.1.4. Банкны өөрийн хөрөнгийг тогтоосон хугацаанд нэмэгдүүлэхийг үүрэг болгох;

48.1.5. Банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

48.1.6. Банкны удирдах албан тушаалтны урамшууллын тогтолцоо нь банкны өөрийн хөрөнгийн хангалттай байх түвшинд сөргөөр нөлөөлнө гэж дүгнэсэн бол цалин, урамшууллыг хязгаарлах;

48.1.7. Тодорхой үйл ажиллагаа явуулах, хэлцэл гүйлгээ хийхэд Монголбанкаас урьдчилан зөвшөөрөл авахаар тогтоох;

48.1.8. Тухайн банкны нэг улирлын нийт активын дундаж хэмжээ нь өмнөх улирлын нийт активын дундаж хэмжээнээс хэтрэхгүй байх, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах;

48.1.9. Хөрөнгө худалдан авах, банкны нэгж байгуулахыг хориглох;

48.1.10. Банкны үйл ажиллагаа явуулахыг хэсэгчлэн хязгаарлах, түдгэлзүүлэх;

48.1.11. Хөрөнгө худалдах, банкны нэгжийг татан буулгахыг шаардах;

48.1.16. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.

2019.04.08

Капитал банк цаашид хэвийн үйл ажиллагаа эрхлэх чадваргүй болсон тул албадан татан буулгав.

КАПИТАЛ БАНКИЙГ ТАТАН БУУЛГАСАН ТАЛААР ХЭН, ЮУ ХЭЛЭВ?

Монголбанкнаас Капитал банкгийг татан буулгаж, эрх хүлээн авагч томилох шийдвэр гаргасантай холбоотойгоор эдийн засагч, судлаачид байр сууриа илэрхийллээ.



ОУВС-ИЙН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ
НЕЙЛ САКЕР

Активын чанарын үнэлгээгээр олонх банк хангалттай хэмжээнд өөрийн хөрөнгөтэй болох шаардлагатай гэдэг нь тодорхой гарсан. Ганц хоёр банк өөрийн хөрөнгийн дутагдалтай нь ил болсон. Тэрхүү үр дүнд үндэслээд системийн ач холбогдолгүй, жижиг банкуудыг хэрэв тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж чадахгүй бол татан буулгах шийдвэрийг Монголбанк хуулийнхаа дагуу тодорхой болгоод мэдэгдсэн. Системийн ач холбогдолтой банкуудын хувьд төрөөс арай өөр байдлаар оролцох шаардлагатай болсон. Харин энэ долоо хоногт нэг банкгийг татан буулгах шийдвэр гарсан. Банкууд Монголбанкнаас тогтоосон зохистой байдлын үзүүлэлтүүдийг хангаж ажиллах ёстой байдаг. Харин "Капитал" банкны хувьд нэлээд удаан хугацаанд зохистой харьцаануудыг хангалгүй ажиллаж ирснээс гадна хангах боломж гаргасан хугацаанд нь шаардлагыг хангаж чадаагүй учраас ийм шийдвэр гаргасан байгаа. Энэ шийдвэр гарснаар Монголын банк санхүүгийн салбарын тогтвортой байдалд сөрөг үр дагавар гарахгүй. Яагаад гэвэл системийн ач холбогдолтой биш, жижиг банк байгаа.



ЭДИЙН ЗАСАГЧ **Г.БУМЧИМЭГ**

Банкны систем өөрөө нэг төрлийн зах зээл. Бизнесийн нэг салбар шүү дээ. Энэ зах зээлд хөрөнгө оруулалт хийж буй хүмүүс тодорхой хэмжээгээр эрсдэл хүлээж байгаа. Эрсдэлээсээ давсан ашиг олж чадахгүй бол өрсөлдөөнөөс хасагдах нь зах зээлийн хууль. Банкны салбар өөрөө зохицуулалттай зах зээл хэдий ч энд шударгаар өрсөлдөх нөхцөлийг хангах нь чухал. Өөрөөр хэлбэл, Төв банкнаас нэг ч банкгийг дампууруулахгүй гээд энэ салбарт хэтэрхий давуу тал, илүү их боломж олгох нь зохисгүй. Энэ салбарт цэвэр, шударга өрсөлдөөний үр дүнд бий болсон зээл болон хадгаламжийн хүү тогтох ёстой. Банкууд тодорхой хэмжээгээр эрсдэл хүлээгээд хэрэглэгчдэд хамгийн сайн бүтээгдэхүүнийг хамгийн боломжийн үнээр хүргэхийн төлөө өрсөлдөөнд орж байгаа. Энэ бизнесийн өрсөлдөөнд ялж, ялагдах орчныг Монголбанк нээлттэй үлдээж өгч байгаа нь зөв. Ерөнхийдөө санхүүгийн тогтвортой байдал гэж юу вэ гэдгийг юуны өмнө тайлбарлая. Санхүүгийн тогтвортой байдал гэдэг нь нэг ч банк дампуурахгүй байхыг хэлнэ гэж ойлгож болохгүй. Санхүүгийн тогтвортой байдал гэдэг нь эдийн засаг өсөлттэй, уналттай аль ч үед банкны систем зөв ажилладаг байхыг хэлнэ.



ЭДИЙН ЗАСАГЧ **Ч.АНХБАЯР**

Монголбанк санхүү, банкны системийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй. Энэ тогтвортой байдлыг хэмждэг өөрийн гэсэн үзүүлэлттэй. Үүнийг банкны зохистой харьцааны үзүүлэлт гэж нэрлэдэг. Тухайлбал, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 25 хувиас их байх ёстой. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ 12 хувиас өндөр байх зэрэг болно. Зээлийн чанаргүйдэл таван хувиас бага байх ёстой гэсэн заалтууд бий. Монголбанк сар болгон санхүүгийн шалгалт хийгээд албан тоот явуулдаг. Тэдгээр албан тоотыг харвал салбарын дундажтай харьцуулахад тухайн банк хаана явааг урьдчилан үнэлдэг. Мэдээж болохгүй зүйлсийг болгох талаас нь тодорхой хугацаа өгдөг. Түүнчлэн Банкны тухай хуулиараа хүндрэл илэрсэн үед түүнээс гарах тодорхой хугацаатай төлөвлөгөөг ч гаргаж өгөх ёстой. Өөрөөр хэлбэл, Монголбанкны зүгээс боломж, хугацаагаар хангалттай дэмжсэн гэж ойлгосон.



ЭДИЙН ЗАСАГЧ **Б.ТҮВШИНТӨГС**

Урьд өмнө нь дампуурч байсан банкуудтай харьцуулахад, Капитал банкны дампуурал тэс өөр зохицуулалт, өөр тогтолцооны үед болж байгаа гэдгээрээ онцлогтой. Капитал банк дампуурч буй сүүлчийн банк биш. Харамсалтай нь ирээдүйд ч ийм зүйл тохиолдоно. Үүнийг бүх цаг үеийн Төв банкны удирдлагууд болоод УИХ, Засгийн газрын бодлого боловсруулагчид харж байсан. Тиймээс ийм хүндрэл тохиолдвол хэрхэн даван туулах вэ гэдэг асуудалд бодлогын шийдэл гаргасан байдаг. Өмнө нь Сэргээлт босголт, Хадгаламж, Зоос, Анод гээд л банкууд дампуурч л байсан. Тэр болгонд төр өөрөө эрсдэлийг нь хүлээж ирсэн. Засгийн газар, Монголбанк дампуурсан банкны алдагдлыг өөр дээрээ шилжүүлэн авдаг байсан. Банкны эзний алдааг төр буюу татвар төлөгч бид үүрч ирсэн. Ингээд яваад байж болохгүйг бид бүгд мэдэж байна. Өөрөөр хэлбэл, төр хүмүүсийн эрсдэлд өртсөн хадгаламжийн мөнгийг олгож ирсэн. Гэтэл дампуурсан банкнаас гарсан зээлийг эргэн төлүүлэх буюу төр гаргасан мөнгөө буцаан олж авахад асар их хүндрэл үүссэн. Татвар төлөгчдийн мөнгийг үрэн таран хийдэг энэ тогтолцоог сууриар нь өөрчлөхийн тулд 2013 онд хадгаламжийн даатгалыг бий болгосон. Хадгаламжийн даатгалын тогтолцоо бол төр төлөөсийг нь үүрдэг буруу тогтолцоог халах гэж оролдож буй эхний алхам. Одоогийн байдлаар 100 хувь халж чадаагүй ч эхний алхам нь хийгдсэн.

КАПИТАЛ БАНК ХХК-Д АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

"Капитал банк" ХХК нь банкны үйл ажиллагааны зохистой харьцааны зарим шалгуур үзүүлэлтүүдийг хангаж чадахгүй болж эхэлсэн буюу 2015 оны 10 дугаар сараас 2019 оны 4-р сар хүртэлх хугацаанд Монголбанкнаас зөрчил дутагдлыг арилгах, банкны засаглалыг сайжруулах талаар холбогдох хууль, журмын дагуу шат дараатай, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тухай бүр авч байв. Үүнд:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хугацаатай үүрэг даалгаврыг өгөх;
- Торгууль ногдуулах;
- Эрсдэлийн сан нэмж байгуулах;
- Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн дагуу зөрчлийн хэрэг үүсгэх;
- Банкны эрхлэх үйл ажиллагааны зарим зөвшөөрлийг зогсоож, зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгаврыг өгөх;
- Банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;
- ТУЗ болон Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг зогсоох;
- Зээл төлүүлэх, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байлгах;
- Зарим хөрөнгийг худалдах, банкны нэгжийг татан буулгахыг шаардах;

- Монголбанкны хянагч, тусгай төлөөлөгч томилох;
- Шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.

Үүний зэрэгцээ ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд тус банкинд олон улсын стандартын дагуу активын чанарын үнэлгээг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэн, өөрийн хөрөнгийн дутагдлыг тогтоож, дутагдлыг арилгах хугацааг зааж өгч байв. Капитал банк болон бусад бүх арилжааны банкинд активын чанарын үнэлгээг 2017 оны 8-р сараас эхлүүлж, 2018 оны 2 дугаар сард үр дүнгийн талаар мэдээлсэн бөгөөд тус үнэлгээгээр банкуудын зээлийн багцын чанарыг үнэлэхээс гадна тэдгээрийн үйл ажиллагааны бодлого, журам, зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, барьцаа хөрөнгө, гуравдугаар түвшний хөрөнгө зэргийг үнэлэх ажиллагаа хийгдсэн болно. Түүнчлэн, банкууд өөрийн хөрөнгийн түвшинг 2021 он хүртэлх хугацаанд хангах талаар бизнес төлөвлөгөөг боловсруулан Монголбанкинд ирүүлэх нийтлэг шаардлагыг тавьж, санхүүгийн үзүүлэлтэд эрсдэлийн сорилын шинжилгээг хийх замаар өөрийн хөрөнгийн хүрэлцээний дутагдлыг тодорхойлсон болно. Капитал банк тус үнэлгээгээр өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан тул 9 сарын хугацаатай үүрэг даалгаврыг Монголбанкнаас өгч, 2018 оны 12 дугаар сард багтаан бүрэн хангасан

байх шаардлагыг тавьсан болно.

Капитал банк нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж чадаагүйгээс гадна, Монголбанкнаас Төв банк (Монголбанк)-ны тухай, Банкны тухай хуулийн дагуу авсан арга хэмжээний биелэлт хангагдаагүй, Банкны тухай хуулийн дагуу Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авах үндэслэлгүй байв. Тус банкны өр төлбөр нь активаасаа 279 тэрбумаар хэтэрсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 0.5 хувь болсноор хадгаламж эзэмшигч, харилцагч болон мөнгөн төлбөрийн шаардах эрх бүхий этгээдийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болж, банк хоорондын төлбөр тооцооны гүйлгээг саатуулж, банкны заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж чадахгүйд хүрч, цаашид хэвийн үйл ажиллагаа эрхлэх чадваргүй болсон тул дараагийн арга хэмжээг авах шаардлага үүссэн болно.

Иймд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, албадлагын арга хэмжээ авах"; 28

дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтад “Монголбанкны Ерөнхийлөгч Банкны хяналт шалгалтын хорооны зөвлөмжийг харгалзан шийдвэр гаргах, арга хэмжээ авах”; Банкны тухай хуулийн 27.1.6 дахь заалт дахь банк Монголбанкны урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй, шаардлагыг биелүүлээгүй нь банкны үйл ажиллагаа, төлбөрийн чадварыг алдагдуулахад хүргэх ноцтой нөхцөл байдал үүсгэсэн; мөн хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “... албадлагын арга хэмжээний хүрээнд банк байгуулах тусгай зөвшөөрлийг цуцалсан”, “банкинд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлэх боломжгүй тухай Монголбанкны шийдвэр гаргасан үндэслэлээр банкиг албадан татан буулгах шийдвэр гаргаж, банкны эрх хүлээн авагч томилно” гэснийг тус тус үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар Капитал банкиг албадан татан буулгах шийдвэр гаргаж, банкны эрх хүлээн авагч томиллоо.

Банкны эрх хүлээн авагч томилогдсоноор Капитал банкны үйл ажиллагааг зогсоон, тус банкны тайлан тэнцэл, хөрөнгийг хүлээн авахаар ажиллаж байгаа бөгөөд харилцах, хадгаламж эзэмшигчдийн нөхөн төлбөр Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Банкны тухай хуульд зааснаар шийдвэрлэгдэнэ. 20 сая төгрөгөөс доош дүнтэй харилцах, хадгаламж эзэмшигчдийн нөхөн төлбөрийг ойрын хугацаанд Хаан банкаар дамжуулан олгох ба даатгалын нөхөн төлбөрийг Хадгаламжийн даатгалын сангийн эх үүсвэрээс яаралтай олгохын тулд Хаан

банк, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран ажиллаж байна. Харин 20 сая төгрөгөөс дээш дүнтэй харилцах, хадгаламж эзэмшигчдийн нэхэмжлэлийг Банкны эрх хүлээн авагч удахгүй авч эхлэх бөгөөд мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэнэ.

Капитал банк нь банкны системийн 1.1 хувийг бүрдүүлдэг байсан бөгөөд системийн нөлөө бүхий банк биш тул эдийн засаг дахь санхүүгийн зуучлалд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Монголбанк үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг ханган ажиллаж байна.

[1] Банкны тухай хуулийн 48.1.Банк нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосондүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй, эсхүл найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол Монголбанкнаас дараах арга хэмжээг авна:

48.1.1.зөрчил, дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх;

48.1.2.зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

48.1.3.тогтворжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтоосон түвшинд хүргэхийг даалгах;

48.1.4.банкны өөрийн хөрөнгийг тогтоосон хугацаанд нэмэгдүүлэхийг үүрэг болгох;

48.1.5.банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод

хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

48.1.6.банкны удирдах албан тушаалтны урамшууллын тогтолцоо нь банкны өөрийн хөрөнгийн хангалттай байх түвшинд сөргөөр нөлөөлнө гэж Монголбанк дүгнэсэн бол цалин, урамшууллыг хязгаарлах;

48.1.7.тодорхой үйл ажиллагаа явуулах, хэлцэл гүйлгээ хийхэд Монголбанкаас урьдчилан зөвшөөрөл авахаар тогтоох;

48.1.8.тухайн банкны нэг улирлын нийт активын дундаж хэмжээ нь өмнөх улирлын нийт активын дундаж хэмжээнээс хэтрэхгүй байх, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах;

48.1.9.хөрөнгө худалдан авах, банкны нэгж байгуулахыг хориглох;

48.1.10.банкны үйл ажиллагаа явуулахыг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, түдгэлзүүлэх;

48.1.11.хөрөнгө худалдах, банкны нэгжийг татан буулгахыг шаардах;

48.1.12.банкны гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас түдгэлзүүлэх, чөлөөлөх;

48.1.13.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, чөлөөлөх;

48.1.14.энэ хуулийн 48.1.1-48.1.13-т заасан арга хэмжээг банк биелүүлээгүй бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх;

48.1.15.нөхцөлт удирдлагын арга хэмжээ авах;

48.1.16.Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.

Монголбанк
2019 оны 4-р сарын 13

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

САЙН МАЛЧНЫ ӨРГӨМЖЛӨЛ

1940 оноос Монгол улсын төр засаг малын тоо толгой, ашиг шимийг нэмэгдүүлэх, малчин ардын хувийн аж ахуйг хөгжүүлэх, сонирхол санаачлагыг нь урамшуулах зорилгоор "Улсын сайн малчин" цол бий болгожээ. Маршал Х.Чойбалсан өөрөө үүнд ихэд анхаарч, хөдөө орон нутагт биечлэн ажиллаж, газар дээр нь одон тэмдгийг нь гардуулахын зэрэгцээ, бараа таваараар урамшуулж байжээ.

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1944 оны тогтоолоор 1945 оны анхны уг цол тэмдгийг Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын малчин Чойдорж хүртэж, сүргийн олонхи нь тэмээ байсан учир шавж байгаа ширээ бөхтэй орсон буурын баримлын хамт дурсгажээ.

1945 онд 97 сайн малчныг шагнаад түр зогсчээ.

АЗАРГА

Жин: 2511.3 гр

16.8 x 16.9 x 7.5 см

Зөв талын урд хөлөөрөө газар цавчилж, толгойгоо хаялан, чихээ соотойлгон зогсож буй азарганы дүрийг цагаан мөнгөөр хөөмөлдөж, суурийг нь усан хээгээр тойруулан чимэглэжээ.

БУУР

Жин: 4904 гр

21.5 x 16.8 x 8.3 см

Шилээ шөргөөн, шавж буй, орсон буурын дүрийг цагаан мөнгөөр хөөмөлдөж, суурийг нь усан хээгээр тойруулан чимэглэсэн.

БУХ

Жин: 1981 гр

12.5 x 16.2 x 7.1 см

Бухын дүрийг цагаан мөнгөөр хөөмөлдөж, суурийг нь усан хээгээр тойруулан чимэглэжээ.

ХУЦ

Жин: 1255 гр

10.5 x 11.6 x 6.5 см

Толгойгоо үл ялиг зөв тал руу эргүүлэн зогсож байгаа даргар эвэртэй хуцны баримлыг цагаан мөнгөөр хөөмөлдөж, суурийг нь усан хээгээр тойруулан чимэглэсэн.

УХНА

Жин: 963.4 гр

13.3 x 11.6 x 6.5 см

Алсыг ширтэж буй байдалтай дүрсэлсэн сэлмэн эвэрт ухныг цагаан мөнгөөр хөөмөлдөж, суурийг нь усан хээгээр тойруулан чимэглэжээ.



ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙХ НЬ ҮНИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЧУХАЛ ХҮЧИН ЗҮЙЛ

ХАРААТ БУС ТӨВ БАНКНЫ АЧ ХОЛБОГДОЛ

Макро эдийн засгийг Засгийн газраас сангийн бодлогоор удирдахын зэрэгцээ Засгийн газраас хараат бус төв банк гэдэг институцид мөнгөний бодлогыг хариуцуулдаг нь өнөөгийн олон улсын жишиг болсон. Төв банкуудыг ийнхүү хараат бус болгосон гол шалтгаан нь мөнгөний бодлогод “цаг хугацааны нийцгүй байдал”-ын асуудлыг шийдэх зорилготой юм. Татварын мөнгө хэзээд хязгаарлагдмал байдаг бөгөөд улстөрчдийн амлалт бүрийг санхүүжүүлж хүрэлцэхгүй байх нь түгээмэл тул төв банкныг нэмэлт “мөнгөний авдар” гэж харах нь түгээмэл. Улмаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж улс орныг хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор төв банкаар мөнгө хэвлүүлсэн туршлага олон улсад цөөнгүй. Гэхдээ эдийн засгийн өсөлт хөгжлийн суурь нь өөрөө боловсрол, бүтээмж байдаг тул энэ гол тулгуураа сайжруулахгүйгээр цаасан мөнгө их хэвлэх нь түр зуур өсөлтийг бий болголоо ч, урт хугацаандаа эдийн засагтаа сөрөг үр дагаврыг авчрах нь их байв. Тухайлбал, уушийн газар 2 пиво захиад 2 дахь пиво нь бүлээн болохоос өмнө үнэ нь нэмэгддэг (тийм учраас анх захихдаа 2-ыг захидаг) байсан Германы 1923 оны гиперинфляци, Зимбабвед 2008 онд инфляци 231 сая хувьд хүрч байсан хямралын үе, сүүлийн жишээ гэвэл 19 хоног бүрт үнийн түвшин 2 дахин өссөн 2018 оны Венесуелыг дурдаж болно. Иймд алс хэтдээ эдийн засагтаа хортой үр дагавартай бодлогоос сэргийлэх, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нам дор инфляцийг хадгалахад нийцтэй бодлого явуулахад Төв банкны мөнгөний бодлогын шийдвэрүүд мэргэжлийн байж, улстөрөөс хараат бус байх нь чухал юм.

МОНГОЛБАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛД ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

Монголбанкны үндсэн зорилтыг олон улсын жишигт нийцүүлэх: Дунд хугацааны үнийн тогтвортой байдлыг хангах

Төв банкны тухай хуулийн 4.1-т “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино” гэж заасан байдаг нь давхар утгыг илэрхийлдэг. “Төгрөгийн тогтвортой байдал” гэдэг нь нэг талаас төгрөгийн худалдан авах чадварын тогтвортой байдал буюу дотоод үнийн тогтвортой байдал, нөгөө талаас төгрөгийн гадаад валюттай харьцах үнийн тогтвортой байдал буюу төгрөгийн ханшийн тогтвортой байдал гэж ойлгогддог. Энэхүү салаа утга Төв банк хэр хариуцлагатай ажилласныг хэмжихэд тодорхой бус байдал үүсгэх эрсдэлтэй. Мөн үндсэн зорилт нарийвчлан тодорхойлогдоогүй байгаа нь Монголбанкны бодлогын арга хэрэгслээр удирдах боломжгүй үүргийг хүлээлгэж, Төв банкны хараат бус байдалд эрсдэл учруулсаар ирсэн байна.

Хэдийгээр i) Төв банкны тухай хуулийн 22.2-т “Монголбанк гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх...” хэмээн томъёолсон нь ханшийн уян хатан байдлыг илэрхийлэхийн зэрэгцээ ii) Монголбанк жил бүр Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг УИХ-д өргөн барихдаа мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляцийн тодорхой түвшнээр тодорхойлдог боловч олон нийтийн дунд “Төгрөгийн ханшийг тогтмол байлгах нь Монголбанкны үүрэг” гэсэн ойлголт түгээмэл юм. SICA (2016) түүвэр судалгаагаар Улаанбаатарт Монголбанкны үндсэн үүрэг зорилтыг олон нийт төдийлөн сайн мэдэхгүй гэдэг

үр дүн гарсан бол Монголбанк (2017)-ны орон нутагт хийсэн түүвэр судалгаагаар “Төв банкны Ерөнхийлөгч байсан бол юу хийх байсан бэ?” гэдэг асуултад судалгаанд оролцогсдын 22% нь төгрөгийг ам.долларын эсрэг тогтвортой байлгана, 18% нь инфляцийг нам тогтвортой түвшинд байлгана гэдэг хариултыг сонгосон байдаг. Монголбанкны үндсэн зорилтыг салаа утгатай томъёолсон нь олон улсын сайн жишгээс зөрүүтэйгээс гадна, олон нийтийн дунд ийнхүү бодит бус хүлээлт үүсгэх, Төв банкны олон нийттэй харилцах харилцааг илүү төвөгтэй болгох, ханшийн хэлбэлзлээс болж Төв банк руу чиглэсэн нийгэм болоод улс төрийн зүгээс шахалт дарамт ирэх шалтгаан болсоор иржээ.

Монголбанкны үндсэн зорилтыг салаа утгаараа “валютын ханшийг тогтворжуулах” гэж ойлгогдохоор тодорхойлох нь бодитоор биелэх үндэслэлгүй тул Төв банкны нэр хүнд болон үйл ажиллагааны тогтвортой байдалд эрсдэл учруулж байна. Ханшийн дэглэмийн хувьд Монгол улс “удирдлагатай хөвөгч” тогтолцоотой улс юм. Хөрөнгийн чөлөөт урсгалтай тул төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь хүчин зүйлс /эдийн засгийн бүтэц, үйлдвэрлэх чадвар, гадаад худалдаа, гадаад өрийн хэмжээ, хөрөнгө оруулалтын таатай орчин гм/, үүнтэй уялдаад төлбөрийн тэнцэл /валютын орох гарах урсгал/-ээр шууд тодорхойлогддог. Төв банк ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг зөөлрүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэрэгслүүдээ /интервенци, бодлогын хүү г.м/ ашиглаж ирсэн. Ханшийн уян хатан байдал нь Монгол Улс шиг жижиг, нээлттэй эдийн засагтай оронд гадаад шокийг шингээх, гадаад, дотоод секторын тэнцвэрийг хангахад зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх ач холбогдолтой байдаг. Харин ханшийн тогтмол дэглэмийг хэрэгжүүлэхэд нэг зайлшгүй суурь тулгуур нь болдог хөрөнгийн хяналт /капитал контрол/ нь гадаад санхүүжилт эдийн засагт чухал ач холбогдолтой манай орны хувьд оновчтой сонголт болохгүй. Учир нь Монгол Улс үндэсний хуримтлал бага бөгөөд өрх, хувийн сектор болон улсын сектор хуримтлал хомс байдаг нь эдийн засгийн өсөлтийг хангах санхүүжилтээ гадаад эх үүсвэрээр бүрдүүлэх зайлшгүй шаардлагад хүргэдэг. Иймд хөрөнгийн чөлөөт урсгалд захиргааны хязгаарлалт тогтоох нь гадаад санхүүжилтийг хумих, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бууруулах эрсдэлийг дагуулна.

Төв банкны үндсэн зорилтыг “үнийн тогтвортой байдал” хэмээн олон улсын жишигт нийцүүлснээр Монголбанк төгрөгийн гадаад валюттай харилцах ханшийг огт анхаарахгүй болно гэсэн үг биш юм. Нэг талаас, Монгол улсад хэрэглээний сагсны 40% нь импортын бараа бүтээгдэхүүнээс хамааралтай тул инфляци тогтвортой байхад ханшийн тогтвортой байдал чухал юм. Иймд ханшийн огцом хэлбэлзлэлийг зөөлрүүлэхэд чиглэсэн бодлогын одоогийн арга хэмжээ нь Төв банк үнийн тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд хэвээр хадгалагдах болно. Харин Монголбанкны үндсэн зорилтыг салаа утгагүй, олон улсын жишигт нийцүүлэн илүү нарийсган тодорхойлж өгснөөр Монголбанк үндсэн зорилттой нийцтэй бус бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрсдэлийг хязгаарлаж, илүү хариуцлагатай бодлого хэрэгжүүлэх хөшүүрэг болох болно. Нөгөө талаас ханшийн тогтвортой байдал нь санхүүгийн тогтвортой байдалтай уялдах тул Төв банк ханшийн богино хугацааны огцом савлагаанаас сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авах нь Төв банкны тухай хуулиар ногдсон Монголбанкны дагалдах зорилготой нийцтэй юм.

Монголбанкны үндсэн зорилт илүү ойлгомжтой болсноор олон нийттэй харилцах үйл ажиллагаа илүү хялбар болох, мөнгөний бодлогын үр дүнтэй байдал дээшлэх, улмаар Төв банкинд итгэх итгэл, хараат бус байдалд эерэг нөлөөтэй.

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг жил болгон шинэчилж батлах нь оновчтой бус

Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10.2-т жил бүр төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг УИХ батлахаар заасан байдаг. Гэвч мөнгөний бодлогыг томъёолох, хэрэгжүүлэх сайн жишгээс зөрүүтэй эдгээр хуулийн заалт нь үр дүнтэй мөнгөний бодлого хэрэгжих нөхцөлийг хязгаарлах, Төв банкны үйл ажиллагааны бие даасан байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл үүсгэж зарим тохиолдолд эрсдэл бодитоор биелэх тохиолдол ч байв.

Нэгдүгээрт, инфляцийн зорилтыг мөнгөний бодлогын үр нөлөө илэрч дуусахааргүй богино хугацаагаар томъёолох нь оновчгүй бөгөөд бодит бус юм. Мөнгөний бодлогын шийдвэр нь зээл, хүү, валютын ханш, хүлээлт, хөрөнгийн үнэ зэрэг

гол сувгуудаар дамжин хэрэглээ, хөрөнгө оруулалт, гадаад худалдаа, улмаар эдийн засгийн идэвхжилд нөлөөлж, инфляцид үзүүлэх нөлөө нь нэг жилээс урт хугацаанд үргэлжилдэг. Иймээс мөнгөний бодлогыг тодорхойлох, бодлогын үр нөлөөг тооцохдоо бусад төв банкууд ихэвчлэн гурван жилийн хугацаанд тооцож, хэмжиж байна. Гэтэл жил бүр Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан инфляцийн зорилтыг дийлэнхдээ 3-аас цөөн жилээр УИХ-аас өөрчлөн тогтоож байв (Зураг 1). Мөнгөний бодлогын эцсийн үр дүн эдийн засагт бүрэн илрэхээс нь өмнө инфляцийн зорилтыг ийнхүү ойрхон давтамжтай өөрчлөх нь бодлогын нөлөөллийг бууруулах, дотоод, гадаадын зах зээл дээр тодорхой бус байдал үүсгэх, бодлогын үр дүнг хэмжих боломжгүй болгох зэрэг хүндрэлийг үүсгэж байв. Иймд үнийн тогтвортой байдлыг хангахын тулд инфляцийг шат дараатай буулгах ерөнхий стратегийн хүрээнд инфляцийн зорилтыг мөнгөний бодлогын үр нөлөө илэрч амжихгүй богино хугацаанд буюу жил тутам шинэчлэх боломжтой байгааг өөрчлөх шаардлага үүсч байна.

Зураг 1 Инфляцийн гүйцэтгэл ба зорилт: 1999-2018



Үүний зэрэгцээ, Монгол улс газарзүйн байрлал, хүн амын тоо, цаг агаарын онцлог зэрэг суурь өгөгдөл; орлогын түвшин, үйлдвэрлэх чадавхи, дэд бүтцийн хөгжил зэрэг эдийн засгийн суурь хүчин зүйлс; институцийн хөгжил, макро бодлогын сахилга бат, соёл болон нийгмийн онцлог, хэрэглэх зан төлөвөөс шалтгаалаад эрэлт болон нийлүүлэлтийн гаралтай шоконд илүү өртөмтгий, эмзэг эдийн засгийн бүтэцтэй. Энэ нь үнийн түвшний хэлбэлзэлд тусгалаа олж, инфляци ижил орлогын түвшинтэй бусад оронтой харьцуулахад өндөр бөгөөд савлагаа ихтэй явж ирсэн байдаг (Barnett et al, 2012).

Инфляцийн зорилтыг нэг жилийн хугацаатай хатуу томьёолох бус, дунд урт хугацаанд тогтворжуулах зорилтот түвшнийг тодорхойлсноор инфляцийг онилох уян хатан бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх орон зайг олгоно. Дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийн шок, цаг агаараас үүдэлтэй хүнсний бүтээгдэхүүнийн үнийн шок зэрэг инфляцид савлагаа үзүүлдэг нийлүүлэлтийн чанартай хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляци зарим хугацаанд түр зуур зорилтоос давах тохиолдол бий. Энэ үед мөнгөний бодлогоор хариу үйлдэл үзүүлэх нь бодит эдийн засгийн идэвхжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Иймд Төв банкны тухай хуулиар тодорхойлсон зорилтыг Монголбанк ханган ажиллаж, биелэлтээ ил тодоор тайлагнаж байх үед жил бүр мөнгөний бодлогын зорилтыг хэлэлцэх, өөрчлөх шаардлагагүй юм. Жил бүр Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлж буй өнөөгийн жишиг нь зорилтын болон хэрэгслийн хараат бус байдлыг цаад агуулгаараа бууруулж байна гэж дүгнэж болох юм.

Хоёрдугаарт, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд Монголбанкны хуулиар зөвшөөрөгдөөгүй, эсхүл Төв банкны үндсэн зорилтод нийцгүй үйл ажиллагааг ч явуулах заалтыг шургуулах боломжийг улс төрчдөд олгодог нь Төв банкны үйл ажиллагааны бие даасан байдал, эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэлийг дагуулдаг. Монголбанкны үйл ажиллагаанаас мөнгөний бодлогыг үнийн түвшин, эдийн засгийн өсөлт болон бусад буюу 3-аас олон зорилтыг биелүүлэхэд чиглэсэн байна гэж дүгнэх тохиолдол ч бий (IMF, 2015). Хоорондоо зөрчилдөх эсхүл нэгэн зэрэг хэрэгжүүлэх боломжгүй болон эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөн улмаар нэг хүнд ногдох ДНБ бага байдаг зүй тогтол (BIS, 2009)-оос үзэхэд Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн зорилтыг нарийвчлан тодорхойлж, зорилтоос хазайлгахгүй байх нь чухал юм. Ингэснээр нь төсвийн нэгдмэл байх чанар алдагдах, валютын нөөц шавхагдаж ханшийн хямралын эрсдэлд хүргэх, дунд урт хугацаанд үнийн тогтвортой байдал алдагдах эрсдэл үүсгэх, дунд хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлөх, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх зэрэг олон эрсдэлээс сэргийлэх боломжтой.

Төв банкны тухай хууль 1996 онд анх батлагдсанаас хойш ил, далд хэлбэрээр Монголбанкны бие даасан, хараат бус байдалд улс төрийн нөлөө байсаар ирсний сүүлийн том жишээ нь 2012-2016 онд хэрэгжүүлсэн 7.2 их наяд төгрөгийн төсвийн шинжтэй арга хэмжээ байсан бөгөөд олон сөрөг үр дагаврыг эдийн засагт бий болгожээ (Д.Ган-Очир, 2019). Төв банк улс төрийн шахалтаар эдийн засгийн түр зуурын идэвхжилийг дэмжих нь макро тогтвортой байдлыг алдагдуулах, эдийн засгийг хүндрэл рүү түлхэх эрсдэлтэйг харуулсан сургамж болон үлджээ. Иймд цаашид Монголбанк зөвхөн хуулиар ногдсон үндсэн зорилтоо дунд хугацаанд хангахад чиглэсэн бие даасан бодлого явуулах нь чухал бөгөөд, аливаа хөндлөнгийн институцээс чиглэл, зөвлөмж хүлээж авлаа ч үндсэн зорилттой нийцгүй үед биелүүлэхгүй байх хууль эрх зүйн дархлааг бүрдүүлэх нь нэн чухал болж байна.

ХЭРЭГСЛИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

- Хэрэгслийн сонголт: Монголбанкны хувьд мөнгөний бодлогод ашиглах арга хэрэгслийг Төв банкны тухай хуулийн 11.1 зүйлээр тодорхой зааж өгсөн байдаг. Энэ нь мөнгөний бодлогын үндсэн зорилтыг нарийвчлан тодорхойлоогүй, ТМБҮЧ-ийн хүрээнд УИХ-аас үүрэг даалгавар, чиглэл өгөх боломжтой одоогийн хууль эрх зүйн орчинд Төв банк үндсэн зорилтоосоо хазайсан үйл ажиллагаа эрхлэх эрсдэлийг хязгаарлах ач холбогдолтой. Харин үндсэн зорилтыг салаа утгагүйгээр нарийсган тодорхойлж, мөнгөний бодлогын зорилтыг дунд хугацаагаар томъёолж, хөндлөнгийн үүрэг даалгавар зөвлөмжийг биелүүлэх дарамтаас сэргийлсэн эрх зүйн орчин бүрдсэн нөхцөлд Төв банк хэрэгслээ өөрөө сонгох, мөнгөний бодлогын арга хэрэгслийн хараат бус байдлыг эргэн авч үзэх шаардлагатай. Учир нь санхүүгийн зах зээлийн хөгжил, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, ирээдүйд үүсэх сорилт нөхцөл байдлаас хамаараад Төв банк үндсэн зорилтоо хангахад тохиромжтой арга хэрэгслийг хуулийн нарийн хязгаарлалтгүйгээр өөрөө сонгох нь хэрэгслийн хараат бус байдал хангагдах, улмаар тулгарсан сорилтод оновчтой хариу үйлдэл үзүүлэх боломжийг дээшлүүлнэ.
- Бодлого боловсруулах, шийдвэр гаргах процессийн сайжруулалт: Мөнгөний бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа хийх хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэхээс гадна шийдвэр гаргах процессийг үргэлжлүүлэн сайжруулах нь бодлогод итгэх итгэл, улмаар төв банкны хараат бус байдлыг баталгаажуулахад чухал хувь нэмэр болно. 2018 онд нэмэлт өөрчлөлт орсон Төв банкны тухай хуулийн нэг чухал шинэчлэл нь Мөнгөний бодлогын хороотой холбоотой хэсэг бөгөөд бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг сайн засаглалын элементийг Монголбанкинд нэвтрүүлсэн явдал байв. Цаашид УИХ-аас томилогдсон Мөнгөний бодлогын хорооны гишүүдийг хуульд заасан шаардлагад нийцтэй бүтэн бүрэлдэхүүнээр томилж бүрэн эрхийн хугацаагаар нь ажиллуулах, нэгэнт УИХ-аас мэргэжлийн гишүүдийг томилж бодлогын шийдвэрийг гаргах эрхийг олгож байгаа тул мөнгөний бодлогын стратегийн баримт бичиг болох Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг УИХ-аас заавал жил болгон батлах шаардлагагүй юм.
- Макро зохистой бодлого ба төв банкны хараат бус байдал: Макро зохистой бодлого нь олон улсад ч шинэ зүйл бөгөөд зорилгын хэмжүүр, бодлогын шилжих механизм, институцийн хараат бус байдалтай холбоотой нэгдсэн дүгнэлт, нийтлэг жишиг хараахан тогтоогүй байна. Монголбанк 2018 оны Төв банкны тухай хуулийн шинэчлэлээр макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх мандаттай болж, уг бодлогыг нэвтрүүлэх стратегийн хүрээнд мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж буй. Цаашид бодлогыг хэрэгжүүлэх явцдаа олон улсын шилдэг туршлага болон дотоодод хэрэгжүүлсэн бодлогын шийдвэрийн үр дүн, туршлага дээрээ үндэслээд макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ

- Монголбанкны Ерөнхийлөгчийн томилгоо, албан тушаалаас чөлөөлөх асуудал: 1996 онд анх Төв банкны хууль батлагдсанаас хойш

Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаагаа дуусгаж ажилласан ганцхан тохиолдол байгаа нь Монголбанкны хараат бус байдал эмзэг явж ирсний нэг бодит илрэл юм. Хэдийгээр 2018 оны Төв банкны тухай хуулийн шинэчлэлээр Монголбанкны хараат бус байдлыг дээшлүүлэх алхмууд хийгдсэн ч бодит амьдрал дээр бүрэн туршигдаагүй байна. Монголбанкны удирдлагыг Төв банкны үндсэн зорилттой шууд холбоогүй шалтгаанаар албан тушаалаас чөлөөлөх эсхүл хуульд нийцгүй үндэслэлээр огцруулах боломжийг хаах шаардлагатай. Үүний тулд огцруулах саналын босгыг өндөрсгөх нь чухал юм. Түүнчлэн, Төв банкны тухай хуульд заасан үндэслэл нь өөрөө Төв банкны хараат бус байдлыг бодитоор баталгаажуулах дархлаа болсон байх шаардлагатай. Төв банкны тухай хуулийн 26.6-д заасан Монголбанкны удирдлагуудыг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл дунд “үүрэг ажлаа хангалтгүй биелүүлсэн тохиолдолд” (26.6.4) гэж томъёолсон байгаа нь утга агуулгын хувьд тодорхой бус байна.

- Төв банкны санхүүгийн байдал: Монголбанк 2012-2016 онд төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлж, зээлээр гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлсэн зэргээс голлон шалтгаалж алдагдал хурдтай нэмэгдсэн нь Төв банк, мөнгөний бодлогод итгэх итгэлийг бууруулах, цаашлаад төв банкны хараат бус байдлыг эмзэг байдалд оруулах эрсдэлийг үүсгэсээр байна. Иймд алдагдлыг оновчтой хувилбараар бууруулах бодлогыг баримтлах, ингэхдээ Төв банкны хараат бус байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нь чухлаар тавигдаж байна.
- Төв банкны удирдлагын цалин хөлс: Монголбанкны Ерөнхийлөгч нарын цалинг УИХ-аас тогтоож ирсэн жишиг нь хэд хэдэн эрсдэлийг үүсгэх магадлалтай. Улсын санхүүгийн зах зээл, макро эдийн засагт чухал үүрэгтэй институцийг удирдагч албан тушаалтны цалинг өрсөлдөхүйц түвшинд тогтоох нь ажил үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх нэг чухал нөхцөл болно. Мөн цалинг ямар дүрмээр хэрхэн тогтоохоос хамаарч албан

тушаалтанд нөлөө үзүүлэх, хараат бусаар ажиллахад нь нөлөөлөх боломжийг нээлттэй үлдээж буй. Иймд Монголбанкны удирдлагууд албан тушаалаа шударга үнэнчээр гүйцэтгэхийн зэрэгцээ хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй байх цалин хөлсний тогтолцоог хэрхэн бүрдүүлэх вэ гэдэг нь чухал юм.

ИЛ ТОД БАЙДАЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА БА САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

- Ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаа: 2014 оноос хойш Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд олон нийттэй харилцах харилцааг сайжруулах талаарх заалтыг тусгаж Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэх алхмууд хийгдэж буй.¹ Үүний хүрээнд олон нийттэй харилцах арга хэрэгслүүдийг сайжруулах, олон улсын төв банкуудын нийтлэг жишгийг нэвтрүүлэх, Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцах үйл ажиллагааг үнэлж, сайжруулалтуудыг хийх зэрэг ажлууд хийгдсэн байна. Төв банк олон нийттэй харилцах харилцаагаар дамжуулж зах зээл дээрх мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж эдийн засагт оролцоогчдын хүлээлтийг үр дүнтэй удирдах, эдийн засагт тогтвортой байдлыг бий болгох ач холбогдолтой. Иймд цаашид ч Төв банкны хариуцлагатай үйл ажиллагааг дээшлүүлж, бодлогод итгэх итгэлийг сайжруулж, хараат бус байдлыг баталгаажуулахад ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааг сайжруулах ажил үргэлжлэх нь чухал юм.
- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг боловсрол: Нэг талаас төв банкны ил тод байдал, олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулах нь чухал боловч нөгөө талаас олон нийт мэдээллийг хэрхэн хүлээж авч, ойлгох вэ гэдгээс үр дүнтэй байдал нь хамаарна. Мөнгөний бодлогыг үр

¹ ТМБҮЧ 2018 1.4 заалт: “Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, бодлогын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгоно”

ТМБҮЧ 2019 1.4 заалт: 1.4. “Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулж, бодлогын нөлөөг дээшлүүлнэ.”


дүнтэй хэрэгжүүлэхэд зөвхөн санхүүгийн зах зээлийн гол институци оролцогчдоос гадна, эдийн засагт хөдөлмөр эрхэлж санхүүгийн шийдвэр гаргаж буй иргэдийн үйл хөдлөл хэр оновчтой байх вэ гэдэг нөлөөтэй юм. Эдийн засагт оролцогчдын санхүүгийн шийдвэр, үйл хөдлөл хэр оновчтой байх вэ гэдэг нь санхүү эдийн засгийн суурь мэдлэг боловсролоос тодорхой хэмжээнд хамаарах тул төв банкууд санхүүгийн боловсролд чухал ач холбогдол өгч, нийгмийн хариуцлагатай байдлын хүрээнд анхаардаг болсон. Үүний зэрэгцээ олон нийт төв банкны үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй бодлогыг ойлгох чадвар өндөр байх нь төв банкны хараат бус байдлыг чухал гэж үзэх нийгмийн зөвшилцөлд хүрч, төв банкны хараат бус байдалд чухал дэмжлэг болно.

Хуулиар баталгаажуулсан төв банкны хараат бус байдлыг хуулийг өөрчлөх замаар хэзээд эрсдэлд оруулах боломжтой ч, төв банкныг хараат бус байлгах асуудал олон нийтийн дэмжлэгийг хүлээсэн тохиолдолд энэ нь хялбар биш юм. Иймд нэг талаас бодлогын үр дүнтэй байдлыг дээшлүүлэх, нөгөө талаас хараат бус байдлыг илүү баталгаат болгох замаар үндсэн зорилтоо урт хугацаанд биелүүлэхэд олон нийтийн санхүүгийн мэдлэг боловсрол чухал байр суурь эзэлнэ. Монголбанк Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бөгөөд цаашид хувь хүний санхүүгийн боловсролоос гадна, макро эдийн засаг, мөнгөний бодлогын талаарх суурь мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай.


Төв банк ба эдийн засаг

Төв банк хараат бус байдал өндөр орнуудад санхүүгийн зах зээлийн реформ хүчтэй байна


2000-аад оны эхний хагас



Төв банкны хараат бус байдлын индекс өндөр орнуудад инфляци нам түвшинд байна



Төв банкны хараат бус байдал ба эдийн засгийн өсөлт





МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС (2019.04.26)

Сар бүр цаг үеийн асуудлаар мэдээлэл өгдөг Монголбанкны хэвлэлийн бага хурал 2019.04.26 нд болж, сүүлийн 2.9 жилд хийж хэрэгжүүлсэн бодлого шийдвэрийнхээ талаар мэдээлэл өгч, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариуллаа.

БЛҮҮМБЭРГ ТВ: Нэхэмжлэлийн шаардлагыг хангах дарааллын талаар мэдээлэл өгөхгүй юу. Эхлээд иргэдэд олгох уу, эсвэл ААН-д олгоно гэсэн дараалал бий юу?

“Капитал банк” ХХК дахь Банкны эрх хүлээн авагч **М.АДИЛБИШ:**

-Банкны эрх хүлээн авагч, эрх хүлээн авагчийн зөвлөл томилогдсон өдрөөсөө эхлээд тухайн өдрийн банкинд байсан балансад байгаа хөрөнгийг өөрийн хяналтад авах ажлыг хийж дуусгах гэж байна. Энэ хөрөнгийг эхний ээлжинд хяналтандаа авна. Хоёрдугаарт, 20 саяас доош дүнтэй хадгаламжийн даатгалын нөхөн төлбөрийг шилжүүлнэ. Эдгээр нь бүгд шинэ хууль эрх зүйн орчинд явагдана. Яагаад гэвэл, Банкны тухай хууль, Хадгаламжийн даатгалын тухай хууль нь ч шинэ.

Эрх хүлээн авагчийн зөвлөл нь тус банкны актив хөрөнгийг барагдуулж, тухайн хөрөнгөөр нь тус банкнаас үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн төлбөрийг барагдуулах үндсэн чиг үүрэгтэй. Тэгэхээр мөнгөө эрсдэлд оруулсан хүмүүсийн эрх ашгийн төлөө ажиллах юм.

Төлбөр барагдуулах дарааллыг Банкны тухай хуулийн 73.1-д заасан дарааллын дагуу гүйцэтгэнэ.

73 дугаар зүйл.Төлбөр барагдуулах дараалал

73.1. Банкны хөрөнгийг худалдан борлуулсны орлогоос нэхэмжлэлийн шаардлагыг хангахад доор дурдсан дарааллыг баримтална:

73.1.1. Бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн банкнаас гаргуулж байсан төлбөр;

73.1.2. Монголбанкны болон эрх хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал;

73.1.3. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон хувьцаа эзэмшигч нарын хадгаламжаас бусад Банкна дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан даатгагдсан хадгаламж, даатгагдсан хадгаламж эзэмшигчийн шаардах эрхийг шилжүүлэн авсан Хадгаламжийн даатгалын корпорацийн шаардлага;

73.1.4. Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө;

73.1.5. Даатгагдаагүй хадгаламжийн төлбөр;

73.1.6. Банкны эрх бүхий албан тушаалтнаас бусад ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй цалин хөлс;

73.1.7. Монголбанкны шаардах эрх бүхий төлбөрийн шаардлага;

73.1.8. Засгийн газарт төлөх өр төлбөр, албан татвар;

73.1.9. Үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар баталгаажаагүй бусад өр төлбөр;

73.1.10. Хоёрдогч өглөг.

“Капитал банк” ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн зөвлөлийн гишүүн Т.Дэлгэрхүү:

Иргэд нэхэмжлэлийг түрүүлж өгснөөрөө дарааллын түрүүнд орно гэсэн ойлголт байхгүй. Нэхэмжлэл хүлээн авах 60 хоногийн хугацаандаа ачаалал үүсгэхгүйгээр нэхэмжлэлээ багтаагаад өгөхөд болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ: Капитал банкны эрх хүлээн авахад банкны үйл ажиллагаа нь хэвийн байсан, Монголбанк зориудаар дампууруулчихлаа гэсэн яриа иргэдийн дунд байгаа. Үнэхээр банкны үйл ажиллагаа хэвийн байсан уу, хүндрэлд орчихсон байсан уу?

Хяналт шалгалтын газрын Банкны бодлого, бүтцийн өөрчлөлтийн хэлтсийн захирал **Ё.МӨНХБАТ:**

Капитал банкны пассив хөрөнгө нь активаасаа давсан байсан. Төлбөрийн чадваргүй болж, банкны үйл ажиллагаа цаашид хэвийн явагдах боломжгүй болсон нь хуульд тодорхой заагдсан. Тэгэхээр хүндэрсэн банкинд арга хэмжээ авсан гэдэг нь тодорхой, үүнд эргэлзэх зүйл байхгүй.

LIVE ТЕЛЕВИЗ: Капитал банкны үйл ажиллагаа 2015 оноос хэвийн бус болсон гэж байна. Гэтэл Монголбанк 2018 онд банкны системийн үйл ажиллагаа хэвийн гэж мэдэгдэж байсан. Энэ нь иргэдийг буруу мэдээллээр хуурсан хэрэг биш үү?

ХШГ-ын БББӨХ-ийн захирал **Ё.МӨНХБАТ:**

Монголбанкнаас банкны систем ерөнхийдөө тогтвортой байгаа гэж нийтэд нь мэдээлсэн. Капитал банкны хувьд банкны салбарын ердөө 1.1 хувийг эзэлж байгаа. Тус банкиг татан буулгаснаар банкны салбарт сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Тус банкнаас хамгийн сүүлд их хэмжээний зээл олгогдсон уу?

ХШГ-ын БББӨХ-ийн захирал **Ё.МӨНХБАТ:**

Сүүлийн саруудад банкны үйл ажиллагааг хяналтад авч, зарим үйлчилгээг нь хязгаарласан тул сүүлийн үед зээл олгогдоогүй.

ИЙГЛ ТВ: Капитал банкны чанаргүй зээл 80 хувьд хүрсэн гэж байсан. Энэ бол маш олон иргэд хохирох хэмжээнд орчихсон гэсэн үг. Гэтэл яагаад энэ хүртэл нь Монголбанк арга хэмжээ аваагүй явж ирсэн бэ. Ер нь чанаргүй зээл ямар түвшинд хүрэхэд Монголбанк арга хэмжээ авах ёстой талаар журам байна уу?

ХШГ-ын БББӨХ-ийн захирал **Ё.МӨНХБАТ:**

Чанаргүй зээлийн хэмжээг заасан хууль журам байхгүй. Чанаргүй зээлийн хэмжээ харьцангуй өндөр үү гэвэл өндөр. Гэхдээ хуулиа баримтлаад, тодорхой нөхцөлд, тодорхой арга хэмжээ авах ёстой. Бид хуулиа мөрдөх ёстой юм.

ИЙГЛ ТВ: Төрийн 300 гаруй тэрбум төгрөгийг байршуулсан Капитал банк дампуурлаа. Яагаад ийм найдваргүй банк руу төрийн мөнгийг байршуулсан юм бэ?

ХШГ-ын БББӨХ-ийн захирал **Ё.Мөнхбат:**


2015 онд тус банк төлбөр түргэн гүйцэтгэх чадварын асуудалд орж эхлэх үед төрийн их хэмжээний мөнгө аль хэдийнэ байршуулсан байсан бөгөөд тухайн нөхцөл байдалд буцаан татах боломжгүй болсон байсан. Тийм учраас бид нөхцөл байдлыг хяналтдаа аваад, банкны үйл ажиллагааг нь хэвийн хэмжээнд хүргэхээр ажиллаж, арга хэмжээ авсаар ирсэн. Гэсэн хэдий ч үйл ажиллагаа нь хэвийн явагдах боломжгүй болсон учраас татан буулгахад хүрсэн.

Г.Алантай холбоотой, том хадгаламж эзэмшигчид хохирлоо барагдуулахын тулд "Алтжин бөмбөгөр"-ийн хүмүүсийн иргэний үнэмлэхийг авч хадгаламж нээлгэсэн тухай асуудал яригдсан. Үнэхээр ийм зүйл болсон уу?

"Капитал банк" ХХК дахь Банкны Эрх хүлээн авагч **М.АДИЛБИШ:**


Энэ талаар хэвлэлээр нэлээд яригдсан байсан тул бид томилогдож очингуутаа хамгийн түрүүнд үүнийг шалгасан. Тухайн хадгаламж эзэмшигчийн хадгаламжийн хэмжээнд өөрчлөлт ороогүй байсан. Учир нь 20 саяас дээш дүнтэй хадгаламжид хөдөлгөөн хийхийг хориглох тухай Монголбанкны ерөнхийлөгчийн тушаал Капитал банкны удирдлагуудад очсон байсан. Тэр дагуу хуучин удирдлага нь хөдөлгөөн хийгээгүй байсан. Тухайн хүний хувьд ийм гүйлгээ хийх оролдлого хийсэн байсан ч хэрэгжээгүй байсан.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц




- М2 мөнгөний жилийн өсөлт 22.6% -д хүрч 19.7 их наяд ₮-т хүрэв.
- Өмнөх сараас 0.6%-иар буюу 117.2 тэрбум ₮-өөр өсөв.
- Үүнээс, М1 мөнгө 6% (208.2 тэрбум ₮) -иар өсч, бусад хадгаламж 0.6% (91 тэрбум ₮) -иар буурсан байна.
 - М1 → ₮-ийн харилцах 176.7 тэрбум ₮-өөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 31.5 тэрбум ₮-өөр өсөв.
 - Бусад хадгаламж → \$-ийн харилцах 898.9 тэрбум ₮-өөр, \$-ийн хадгаламж 140.7 тэрбум ₮-өөр буурч, ₮-ийн хадгаламж 948.6 тэрбум ₮-өөр нэмэгдсэн байна.


Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц




Зураг 4. Нийт хадгаламж




- Нийт М2 мөнгөний нийлүүлэлтийн 56.6%-ийг ₮-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 14.7%-ийг валютын хадгаламж, 15.5%-ийг ₮-ийн харилцах, 10.1%-ийг валютын харилцах, үлдсэн 3.1%-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 14 их наяд ₮-т хүрснээс 79.5%-ийг иргэдийн хадгаламж, 20.5%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 19%-ийг, байгууллагын хадгаламжийн 27%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 5. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 6. Нийт зээл, гадаад валютын зээл хувь



- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 23.5%-иар өсч 17.3 их наяд төгрөгт,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 30%-иар өсч 9.1 их наяд төгрөгт,
- Хувийн байгууллагынх 16%-иар өсч 8.1 их наяд төгрөгт тус тус хүрчээ.
- Нийт зээлийн 15%-ийг, Иргэдийн зээлийн 1.6%-ийг, хувийн байгууллагын зээлийн 30%-ийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

Зураг 7. Хугацаа хэтэрсэн зээл (салбар бүтэц)



- Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 77%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.
- Бусдыг нь улсын байгууллага, иргэдийн зээл бүрдүүлж байна.

Зураг 8. Чанаргүй зээл (салбарын бүтэц)



- Нийт чанаргүй зээлийн 85%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.
- Бусдыг нь улсын байгууллага, иргэдийн зээл бүрдүүлж байна.

Зураг 9. Тайлант сард олгосон ипотекийн зээл




Тайлант сард банкууд 544 зээлдэгчид 43.2 тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос 12.6% нь хөтөлбөрийн, 87.4% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Зураг 10. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү




Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 12.9% болж өмнөх сараас 0.5 нэгж %-иар, өмнөх жилийн мөн үеэс 1.0 нэгж %-иар тус тус өсчээ.

Зураг 11. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр



- Ипотекийн нийт зээлийн үлдэгдлийн 74.5% нь хөтөлбөрийн зээл, 23.4% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.1% нь бусад эх үүсвэрээр олгосон зээл эзэлж байна.
- Орон нутгийн ипотекийн зээл*-ийн 77.8% нь хөтөлбөрийн зээл, 21.4% нь өөрийн эх үүсвэрээр, 0.8 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Зураг 12. Нийт зээлдэгчдийн тоо болон жилийн өсөлт



ХАЙДУ ХААНЫ

Монгол зоос

1291-1306 он

Жин: 2.1 гр

Уолч: 2.1 см

1291-1306

Нүүр тал: Өгэдэй болон
Цагаадай хааны удмынхны
тамгатай.

Ар тал: Хос дэгрээ тамгатай.





ЖЯАН ПАСКАЛ НГАНУУ: ЭДИЙН ЗАСАГТ САНХҮҮГИЙН СИСТЕМИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ ХАМГААС ЧУХАЛ

Дэлхийн банкны Суурин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч бөгөөд ахлах эдийн засагч, Эдийн засгийн ухааны доктор, ноён Жяан Паскал Нгануутай ярилцлаа.

АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ МОНГОЛЫН БАНКНЫ САЛБАРТ ЭРГЭЛТИЙН ЦЭГ БАЙСАН

Эдийн засагт санхүүгийн системийн тогтвортой байдал хамгаас чухал. Монголын санхүүгийн системийн тогтвортой байдал ямархуу байна вэ?

Монголын санхүүгийн зах зээл сүүлийн хэдэн жил нэлээд өргөжиж байгааг надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Тухайлбал, дэлхийн банкны Глобал Финдекс Мэдээллээс харахад (Global Findex Database), 15-аас дээш насны иргэдийн 92 хувь банкинд данстай байгаа юм. Гэсэн ч Монголын санхүүгийн зах зээл банкны салбараас хэт хамааралтай

хэвээр байгаа бөгөөд аж, ахуйн нэгж, иргэдийн санхүүжилтийн гол эх үүсвэр нь банкны зээл хэвээр байгааг санах хэрэгтэй.

Төвбанк банкны салбарын хяналт, шалгалтын гол бөгөөд мэргэшсэн байгууллагын хувьд үйл ажиллагаа нь доройтсон банкинд шаардлагатай арга хэмжээг авсан.

Өнгөрсөн 2013-16 оны хооронд санхүүгийн зах зээлийн эрсдэл нэлээд нэмэгдсэн бөгөөд банкууд зээлээ бууруулах, эрсдэлгүй актив болох ЗГҮЦ-ыг ихээр худалдаж авч байсан нь ажиглагддаг. Нөгөө талдаа иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэр буурсныг илтгэсэн. Мөн түүнчлэн, тухайн хугацаанд хувийн салбарын ихэнх

зээл орон сууцны зээл байсан бол сүүлийн жил гаруй хугацаанд хэрэглээний зээлийн хэт олголтоос давамгайлж байна.

Энэ нь хувийн салбарт очиж буй зээлийн хүртээмж бага байсныг харуулж байна. Хэрэглээний зээл (цалин, орон сууц, бусад хэрэглээний зээл) нийт зээлийн 50 орчим хувийг бүрдүүлж байгааг анхаарах хэрэгтэй. Нийт бүртгэлтэй аж, ахуйн нэгжийн бараг 90 гаруй хувь жижиг, дунд үйлдвэрлэл байгаа өнөөгийн нөхцөлд тэдгээр нь үйл ажиллагаагаа өргөтгөх санхүүгийн хүртээмж хангалттай бус хэвээр байгааг санах хэрэгтэй. Үүнийг банкуудаас шаардаж буй барьцаа хөрөнгө өндөр, зээлийн өндөр хүү болон зээлийн хугацаа

“Төв банк
банкны
салбарын
хяналт,
шалгалтын
гол бөгөөд
мэргэшсэн
байгууллагын
хувьд үйл
ажиллагаа
нь доройтсон
банкинд
шаардлагатай
арга хэмжээг
авсан.”

богино байгаатай голлон холбон тайлбарлахаар байгаа юм.

2013 оны Монголын аж, ахуй нэгжүүдийн судалгаанаас үзэхэд асуулгад оролцсон аж, ахуй нэгжүүдийн 31.7 хувь санхүүжилтийн асуудал тэдгээрийн бизнесийн хамгийн гол хүндрэл болж байна гэж хариулсан нь Зүүн Ази, Номхон Далайн бүс орнуудын дундаж болох 11.3 хувьтай харьцуулахад нэлээд өндөр байгаа юм. Бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад Монголын банкуудын хүү харьцангуй өндөр байгаа ч банкуудын зээлийн чанар сүүлийн жилүүдэд нэлээд муудаад байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь

- 2014 онд 3 хувиас бага байсан бол
- 2016 оны эцэст 9 хувьд хүрч,
- 2018 оны эцсийн байдлаар 10 хувийг даваад байна.

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл нэлээд идэвхжиж байгааг мөн онцолмоор байна. Хөрөнгийн зах зээл бол хувийн салбарын санхүүгийн эх сурвалж байдгийг санах хэрэгтэй. Хэдий идэвхжиж байгаа ч хөрөнгийн зах зээл ДНБ-ий дөнгөж 8 хувийг эзэлж байгаа нь бүс нутгийн орнуудтай харьцуулахад харьцангуй доогуур хэвээр байгаа юм.

Цөөн тооны банкуудын өөрийн хөрөнгө тийм ч хангалттай биш, банкны зохистой харьцааны үзүүлэлтийг чанд мөрдүүлэх асуудлууд, чанаргүй зээлийг бууруулах, сайн менежмент хийх асуудлыг сайтар анхаарах шаардлагатай.

**Олон улсын валютын сангийн
Өргөтгөсөн санхүүжилтийн
хөтөлбөр хэрэгжсэнээр
санхүүгийн системийн
тогтвортой байдал хэрхэн
сайжирсан бэ?**

Сүүлд хийгдсэн активын чанарын үнэлгээ (AQR) үнэндээ Монголын банкны салбарт эргэлтийн цэг байсан гэж хэлж болохоор байгаа юм. Үнэлгээний үр дүн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй сайн гарсан нь эерэг мэдээ байсан. Тухайлбал, 1998 оны Азийн санхүүгийн хямралын үед Азийн орнуудын хийсэн AQR-ын үр тийм сайн байгаагүй. Үнэлгээний үр дүнгээр банкуудын өөрийн хөрөнгийн дутагдал 2017 оны эцсийн байдлаар ДНБ-ий 1.9 хувьтай гарсан.

Засгийн газар болон Төвбанкнаас EFF хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш эдийн засгийн сэргэлт хурдтай явагдсан нь банкны салбарт нэлээд эерэг нөлөө үзүүлсэн. Мөн хууль эрх зүйн орчинд нэлээд дорвитой шинэчлэл хийгдсэн бөгөөд Банкны тухай болон Төвбанкны тухай хуулиуд засаглалын олон улсын стандартын дагуу шинэчлэгдээд байна. Гэвч сайжруулах шаардлагатай зүйлүүд байсаар байна. Тухайлбал, цөөн тооны банкуудын өөрийн хөрөнгө тийм ч хангалттай биш, банкны зохистой харьцааны үзүүлэлтийг чанд мөрдүүлэх асуудлууд (ялангуяа Төвбанкнаас олгосон бодлогын зээлүүд дээр), чанаргүй зээлийг бууруулах, сайн менежмент хийх асуудлуудыг сайтар анхаарах шаардлагатай.

Монголбанк болон Засгийн газар санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулахын тулд цаашид ямар бодлого баримтлах нь зүйтэй вэ?

Дэлхийн банкны Глобал Финдекс Мэдээлэл (Global Findex Database)-ийн үр дүн хэдий сайн байгаа ч хөрөнгийн зах зээлийн хөгжил сул хэвээр байгаа ба хууль, эрх зүйн зарим асуудал, засаглалын чанартай холбоотой асуудлууд гээд анхаарах зүйлс цөөнгүй байна. Банк бус санхүүгийн салбарыг сайжруулах, институцийг бэхжүүлэх, удирдлагыг сайжруулах тал дээр анхаарах нь зүйтэй байх. Уг салбар хэдий жижиг байгаа ч үйл ажиллагааг нь сайтар хянах, СЗХ-ны чадавх, бодлогыг илүү үр дүнтэй, сайжруулах тал дээр бас анхаарахад илүүдэхгүй байх.

Мөн түүнчлэн ОУВС-аас зөвлөдөг шиг, мэргэжлийн хяналт, шалгалтын байгууллага нь үйл ажиллагаа нь хэвийн бус, асуудалтай, зах зээлд эзлэх хувь багатай жижиг банкуудын үйл ажиллагааг зогсоох эрхтэй байдаг. Хангалттай өөрийн хөрөнгөгүй, сул засаглалтай банкуудын хувьд Төвбанкнаас зайлшгүй авах арга хэмжээнүүд нь уг банкиг татан буулгах, эсвэл төр оролцох байдлаар асуудлыг шийддэг. Дээрх арга хэмжээг авахаас гадна холбогдох, журмуудыг нарийн мөрдүүлэх нь санхүүгийн салбарын эрүүл зохистой байдал, сайн засаглал, эдийн засгийн зохистой хөгжил зэргийн суурь болдог. Эцэст нь хэлэхэд аж, ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд гарах сэдлийг төрүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах нь маш чухал.

Тухайлбал, банкуудыг хөрөнгийн зах зээл дээр гаргах нь засаглалыг сайжруулах, хувийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, эцэстээ эдийн засгийн тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг бий болгоход мөн чухал байдаг.

Монголбанкнаас саяхан "Капитал" банкиг татан буулгах шийдвэр гаргасан. Үүнийг санхүүгийн тогтвортой байдлаа хангах алхам гэж харж байна. Та санал нийлүүлэх үү? Үйл ажиллагаа нь үнэхээр доголдсон санхүүгийн байгууллагыг татан буулгах нь харилцагчийн эрх ашгийг хамгаалж буй хэлбэр гэж ойлгож болох уу?

Төвбанкнаас мэдээлснээр, тус банкны зээлийн бараг 80 хувь нь чанаргүй болсон байна. Төвбанк банкны салбарын хяналт, шалгалтын гол бөгөөд мэргэшсэн байгууллагын хувьд үйл ажиллагаа нь доройтсон банкинд шаардлагатай арга хэмжээг авсан. Монголын эдийн засгийн зөв хөгжлийг авчрахад банкны салбар чухал үүрэгтэй бөгөөд банкуудын засаглалыг сайжруулах, тайлан балансыг сайжруулах, хангалттай өөрийн хөрөнгөтэй болгох нь суурь асуудлууд юм. Тиймээс Төвбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь олон улсын нийтлэг жишиг бөгөөд Монголын эдийн засагт зөв хөгжилд чухал шийдвэр гэж бодож байна.


Үйл ажиллагаа нь доголдсон жижиг банкиг дампууруулснаар санхүүгийн зах зээл доргихгүй гэж

бодож байна. Та ямар байр суурьтай байна вэ?

-Зээлийнх 80 хувь нь чанаргүй болсон банкиг татан буулгах шийдвэр нь хянан шалгагчийн ажил юм. Гол асуудал нь дээр дурдсанчлан Монголын эдийн засгийн зөв хөгжлийг авчрахад банкны салбар чухал үүрэгтэй бөгөөд засаглалыг сайжруулах, тайлан балансыг сайжруулах, хангалттай өөрийн хөрөнгөтэй болгох нь эн тэргүүний асуудлууд юм. Мөн түүнчлэн, банкны салбарт төдийлөн хүндрэл үүсэхгүй байх гэж бодож байна. Уг банк нь зах зээлд жижиг хувь эзэлдэг төдийгүй хадгаламж эзэмшигчдийн бараг 99 хувь даатгагдсан байгаа юм.

Миний бодлоор Хадгаламжийн даатгалын корпорац болон хадгаламж эзэмшигчдийг хохиролгүй болгох тал дээр шаардлагатай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч эхлээд байна гэж бодож байна.

Ярилцсанд баярлалаа.



МӨНГӨНИЙ ХЭРГИЙН КОМИСС

САНХҮҮ, МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИНЭ ҮЕ

Тус улсын санхүү, мөнгө зээлийн нэгдсэн тогтолцоо бүрэлдэн тогтоход Сангийн яам, тус яамыг түшиглүүлэн 1925 онд байгуулсан "Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комисс" багагүй үүрэг гүйцэтгэсэн юм.



**ДЕЙЧМАН,
ИСААК НАУМОВИЧ**

1895 онд Хаант Оросын Херсон губернид төрсөн. 1927-1928 онд Монголын Худалдаа аж үйлдвэрийн банкны Ерөнхий хорооны даргаар ажиллаж байв. 1939 онд улс төрийн хилс хэргээр баривчлагдан яллагдаж Качиний шоронд хоригдож байв. 1944 онд дахин баривчлагдаж, 8 жилийн ял сонсож, 3 жилээр улс төрийн эрхээ хасуулжээ. 1954 онд цагаатгажээ.

Комиссын даргаар БНМАУ-ын Аж ахуйн яамны сайд, Эдийн засгийн Зөвлөлийн тэргүүлэгч А.Амар, нарийн бичгийн даргаар Сангийн яамны эрхэлсэн түшмэл С.Довчин, гишүүдэд МХЗЭ-ийн Төв Хорооны дарга Н.Жадамба, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ж.Гэлэгсэнгэ, Худалдаа аж үйлдвэрийн банкны Намсрай нарын бүрэлдэхүүнтэй баталж, улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах мөнгөний бодлого боловсруулах ажлыг хариуцуулжээ. Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комисс Сангийн яамтай хамтран, Худалдаа аж үйлдвэрийн банкны хувь хөрөнгө, мөн үндэсний мөнгөн тэмдэгтийн гүйлгээний ашгаас шимтгэн хуримтлуулах замаар өөрийн улсын тусгай банк нээх бодлого явуулж байсан бололтой гэж М.Ринчин доктор дүгнээд, мөнгөний ханшийг аажмаар шат ахиулж туйлбартай хатуу бодлого баримтлан хэрэгжүүлсний үрээр богино хугацаанд үндэсний зах зээлээсээ гадны мөнгийг зохистой аргаар шахан зайлуулж чадсан төдийгүй гадаадын мөнгө валютаар шахан түрэх (интервенц) хийх гэсэн санхүү эдийн засгийн болон бусад өнгөлзлөгийг цаг тухайд нь тохирох арга хэрэгслээр нь сэрэмжлэн зайлуулж чадсан гэжээ. Тухайлбал, 1926 оны дунд хэрээс хятад худалдаачид гүйлгээнээс янчааныг аажмаар татаж оронд нь зэс зоос оруулах хандлага гаргамагц, Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комисс 1927 оны гуравдугаар сарын 1-н хүртэл монгол төгрөгт нэг зоос 500-г таацуулан авах ба үүнээс хойш гүйлгээнд хэрэглэхгүй байх тухай санал боловсруулж Сангийн яам, Засгийн газраа оруулан батлуулж хэрэгжүүлсэн байна. Мөн 1926 оны эцсээр ЗХУ-аас Алтанбулаг хот болон бусад газраар червонец их хэмжээгээр оруулж

ирэх болсон тул Сангийн яам, Худалдаа аж үйлдвэрийн банкны Ерөнхий хороо, тус комиссоос төгрөгийн гүйлгээнд саадтай болохыг мэдэгдэж таслан зогсоосон байдаг.

Үндэсний мөнгө зээлийн тогтолцоог бүрдүүлэхэд үндэсний мөнгөн тэмдэгт гүйлгээнд оруулахын хамт түүний ханшийг тогтворжуулах, санхүү зээл, төлбөрийн бүх тооцоог төгрөгийн нэгжид шилжүүлэн

“ЮУНЫ УРЬД
ЭРХ ЧӨЛӨӨГӨӨ
АЛДАЛГҮЙ
ХАМГААЛЖ УЛС ГЭР
ҮНДЭС ЯЗГУУРАА
ХӨГЖҮҮЛЭН
БАТАТГАХ НЬ
ТУЙЛЫН ЧУХАЛ
ХЭРЭГ.”

Ц.ДАМБАДОРЖ

тооцож жигдрүүлэх шаардлагатай байв. БНМАУ-ын улсын төсвийн тооцоог 1925 он хүртэл лангаар, 1925 оноос мексик доллараар хийж байсан юм. 1926 оны эцсээр Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комиссоос улсын санхүүгийн тооцоог төгрөгөөр тооцох тухай тогтоол гаргаж Засгийн газар, Худалдаа аж үйлдвэрийн банкнаа уламжилжээ. Комиссын гаргасан тогтоолыг хэлэлцээд Засгийн газар 1926 оны 12 дугаар сарын 17-нд “Худалдаа



ҮНДЭСНИЙ АРДЧИЛСАН ҮЗЭЛТНҮҮД

Тэд БНМАУ-ын тусгаар тогтнолыг бусад улсаар хүлээн зөвшөөрүүлэх, дэлхийн хүчирхэг улс оронтой харилцан бие биеэ хүндэтгэсэн, найрамдалт харилцаа тогтоох, тэдгээртэй улс төр, үзэл суртлын ялгааг үл харгалзан нийгэм, эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, мөн монгол туургатныг нэгтгэж нэгдсэн гэр улс болон хөгжих зорилт дэвшүүлэн тавьж байв.

Зурагт (баруун гар талаас) Б.Цэрэндорж, Г.Гэлэгсэнгэ, Н.Жадамба, С.Магсаржав, А.Амар, Н.Хаянхирваа, Х.Чойбалсан, Ц.Баттөмөр, Ө.Бадрах нар.

гүйлгээг монгол төгрөгөөр тооцох тухай” тогтоол гаргаж 1927 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн “...албан яам ба аливаа худалдааны газрууд, бүх гүйлгээний хэрэг явдлыг монгол төгрөгөөр баримт болгон гүйцэтгүүлэх... олон албан газрууд, албан ба гааль татвар зэрэг зүйлийг төгрөгөөр хурааж монгол төгрөг, хятад янчаан хоёрын ханшийг нэгэн адил бодож гүйцэтгэх... аливаа худалдах, худалдан авах бараа зүйлийн үнийг монгол төгрөгөөр тогтоохоос гадна гадаадын мөнгөөр тогтоож үл болно” гэж заажээ.

1927 онд Сангийн яамны Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комиссоос төгрөгийг алтан баталгаатай болгох санал боловсруулж Засгийн газар оруулжээ. Засгийн газрын 1927 оны 10 дугаар сарын 28-ны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж улсын төгрөгийг алтан баталгаатай болгох явдлыг ёсоор болгон, хятад янчааныг 1928 оны дөрөвдүгээр сарын 1-н хүртэл төгрөгийн нэгэн адил үнээр банкны гүйлгээ зэрэгт зарцуулахгүй болгон мөн алтан баталгааг бэлтгэх ба алтан төгрөгийн хүндийн хэмжээг баримтлан явуулах хугацааг 1928 оны наймдугаар сарын 1-ний наана идэвхийлэн бэлтгэх явдлыг Худалдаа аж үйлдвэрийн банк ба Сангийн яамнаа даалган гүйцэтгүүлэх улмаар БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гарган батлуулахаар тогтоожээ. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 52 тоот тогтоолоор

үндэсний мөнгөн тэмдэгтийн 40 хувийг алтаар баталгаажуулах ба 10 төгрөгийн алтан зоос тус бүр 1 золотник 80 хувьтай тэнцэнэ гэж тогтоожээ. Улсын үндэсний валют төгрөг алтан баталгаатай болсонтой уялдуулан “Аливаа алт, мөнгө ба мөн зүйлээр хийсэн төгрөг зоос, жич тэмдэгт цаас (цаасан мөнгө, чек зэрэг) зэргийг хязгаар нэвтрүүлэн оруулах ба гаргах дүрэм”-ийг шинэчлэн төлөвлөх ажлыг гүйцэтгэсэн байна.

1929 онд гадаадын капиталыг шахан гаргахаар хэрэгжүүлсэн засгийн бодлого нь Монголын зах зээлд барааны хомсдол бий болгож, үнэ зохиомлоор өсөж, мөнгөний ханш буурахад хүрсэн тул Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комисс төгрөгийн ханш, барааны үнийн асуудлыг хэлэлцэж, төгрөгийн ханшийг нэмэгдүүлэх явдлыг 1929 оны дөрөвдүгээр сарын 1-н хүртэл түтгэлзүүлэх, барааны зүйлээр гачигдаж байгаа ба үнэ нэмэгдүүлэх явдлыг устгахын тулд барааны зүйлийг хүрэхүйцээр нэвтрүүлэн авчруулахыг зохих олон газар мэдэгдэж гүйцэтгэх, янчаан авах ханшийг 90 мөнгө болгохыг 12 дугаар сарын 1-нээс эхлэн явуулах зэрэг шийдвэр боловсруулсныг Засгийн газар хянан хэлэлцээд янчааны ханшийг 1929 оны гуравдугаар сарын 1-нээс эхлэн бууруулахаар шийдвэрлэж байв.



ТИЙН ЯЛСАН СУВАРГА

Бурхан багшийн номлол сургаал үхлийг ялан дийлснийг бэлгэднэ. Энэхүү алтан шармал, хөөмөл мөнгөн суваргыг 1985 онд Өмнөговь аймгийн 10 жилийн дунд сургуулийн хичээлийн эрхлэгч С.Жаргалаас Эрдэнэсийн сан худалдан авчээ. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн хөмрөг.



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛД ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Монголбанкнаас улирал бүр эрхлэн гаргадаг
"МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" сэтгүүлийн 10 дахь дугаараас онцлов.

М.ГАНЦЭЦЭГ¹

Хураангуй:

Энэхүү нийтлэлд нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн ирээдүйн хөгжилд технологийн инноваци ялангуяа хиймэл оюун хэрхэн нөлөөлж байгааг онцоллоо. Орчин үед нийгмийн цахим сүлжээ болон технологийн дэвшлийн тусламжтайгаар санхүүгийн болон санхүүгийн бус дата мэдээ олноор бий болж, бизнесийн үйл ажиллагааг автоматжуулах нь ихсэж байна. Үүний дүнд, технологийн дэвшил нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд ч нөлөөгөө үзүүлж эхэлсэн бөгөөд нягтлан бодогчид ажлын байраа хадгалж үлдэхийн тулд технологийн талаарх мэдлэг болон дата мэдээнд дүн шинжилгээ хийх чадвараа нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байна.

ОРШИЛ: Хиймэл оюун ухаан гэдгийг хүний оюун ухаанаар сэтгэн гүйцэтгэх шаардлагатай ажлыг компьютерийн системийн тусламжтайгаар боловсруулж хийх тухай онол гэж тодорхойлсон байна. Компьютерийн тусламжтайгаар их хэмжээний дата мэдээнд шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, тэдгээрийн нарийн төвөгтэй зүй тогтлыг судалж, хамгийн зүй зохистой шийдлийг санал болгох бололцоотой болсон. Иймд хиймэл оюун ухааныг дата мэдээнд дүн шинжилгээ хийх, дижитал тусламж үзүүлэх болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг төрөл бүрийн салбарт ашиглаж эхлээд байна.

Хиймэл оюун ухааныг хөгжүүлсэн нь

Хиймэл оюун ухааны хөгжил дэвшил хүмүүсийн бизнес явуулах арга барилыг өөрчилж байна. ПрайсоутерхаусКуперс аудитын компанийн судалгаагаар хиймэл оюун ухааныг нэвтрүүлснээр бүтээгдэхүүн үйлчилгээний өртөг буурахаас гадна томоохон дата мэдээнд үндэслэн дүн шинжилгээ хийснээр харилцагчдад үзүүлэх үйлчилгээ сайжрах ач холбогдолтой гэж харилцагчдын зүгээс хариулжээ. Тухайлбал, зарим компаниуд өөрсдийн цахим хуудсанд автомат чатын хэсгийг нэвтрүүлж, харилцагчиддаа түргэн шуурхай

үйлчилгээ үзүүлж байна. Роботууд автоматжуулалтын тусламжтайгаар олон дахин давтамжтай хийгддэг ажлуудыг гүйцэтгэж эхэлсэн. Хаккетт Группын тайланд эдгээр технологийн хөгжил дэвшилтэй холбоотойгоор томоохон олон улсын компаниудын 70 орчим хувь нь ирэх 2-3 жилд багтаан санхүүгийн үүрэг функцээ автоматжуулахаар төлөвлөж байгаа талаар дурджээ. Ингэснээр хүний нөөцийн зардал буурахаас гадна хүний гаргах алдаа болон дата мэдээ цуглуулахад зарцуулах хугацаа багасах ач холбогдолтой юм.

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд хиймэл оюун ухааны үзүүлж буй нөлөө

Шинэ технологи, ялангуяа хиймэл оюун ухааны улмаас уламжлалт нягтлан бодогчдын ажил болоод тэдний хэрэгцээ эрс буурах аюул тулгараад байна. Тухайлбал, Форбес сэтгүүлийн сүүлийн үеийн нийтлэлд санхүүгийн салбар тэр дундаа нягтлан бодох бүртгэлийг хиймэл оюун ухааны нөлөөнд өртөж буй топ 10 мэргэжлийн нэгээр нэрлэжээ. Энгийн үгээр бол хиймэл оюун ухаан нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд аюул учруулж буй шинэ дэвшилтэт технологи болоод байна. Хиймэл оюун ухааны технологийн тусламжтайгаар компьютер нягтлан

бодох бүртгэлийн нарийн төвөгтэй ажлуудын талаар суралцан судалж, татварын тайланг бэлтгэх боломжтой болсон. Үүний дүнд, нягтлан бодогчид харилцагчидтайгаа харилцахад илүү цаг зарцуулж, тэдний ирээдүйн бизнесийн үйл ажиллагаанд стратегийн зөвлөгөө, зөвлөмж өгөх боломж нэмэгдсэн. ПрайсоутерхаусКуперс аудитын компанийн судалгаагаар хиймэл оюун ухаан бүхий дижитал туслагчууд санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд ихээхэн нөлөө үзүүлэхээр байгаа бөгөөд ирээдүйд татварын нягтлан бодогчдыг орлох болно хэмээн харилцагчид дүгнэжээ. Бизнес эрхлэгчдийн зүгээс хиймэл оюун ухаан нь технологийн тусламжтайгаар үр өгөөжтэй харилцааг нэмэгдүүлэх, улмаар бүртгэл хөтлөлт зэрэг өдөр тутмын олон дахин давтагддаг ажлуудыг автоматжуулснаар ажилтнуудынхаа бүтээмжийг өсгөх ач холбогдолтой хэмээн эерэгээр хүлээн авч байна. Түүнчлэн хүмүүсийн ялгаварлан гадуурхах байдал буурахаас гадна шийдвэр гаргалтад хүмүүсийн сэтгэл хөдлөл, энэрэнгүй байдал нөлөө үзүүлэх нь багасна. Мөн дижитал хувийн туслагчууд болон автомат дата мэдээний шинжээчид нь бага зардлаар харилцагчдад илүү сайн үйлчилгээ үзүүлж байгаатай холбоотойгоор нийтлэг бизнесийн

шийдэл болж байна. Хиймэл оюун ухааны тусламжтайгаар нягтлан бодогчид нарийн боловсруулсан үнэн зөв дата мэдээнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн илүү сайн зөвлөх үйлчилгээ үзүүлж шийдвэр гаргах бололцоо бүрдсэн. Иймд аудитын компаниуд илүү нээлттэй, чанартай үйлчилгээ үзүүлснээр бизнесийн харилцаагаа улам өргөжүүлэх боломжтой юм.

Аудитын дөрвөн том компани болон томоохон санхүүгийн байгууллагууд бизнесийн үйлчилгээгээ сайжруулж, дижитал ажиллах хүчээ нэмэгдүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан болон их хэмжээний дата мэдээнд дүн шинжилгээ хийхэд зориулж хэдэн тэрбум ам.доллараар хэмжигдэх хөрөнгө оруулалт хийж байна. Кэй Пи Эм Жи аудитын компани Ай Би Эм Ватсон хэмээх танин мэдэхүйн тооцоолох технологийг нэвтрүүлэхээр ажиллаж эхэлсэн. Делойтте аудитын компаниас гэрээ болон баримт бичигт дүн шинжилгээ хийх чадвар бүхий Кира системстэй хамтран ажиллаж байна. Эрнст энд Янг аудитын компани анхныхаа Хиймэл оюун ухааны төвийг Энэтхэг улсад нээхээр төлөвлөж байгаагаа 2017 онд зарласан. ПрайсоутерхаусКуперс аудитын компанийн хувьд хиймэл оюун ухааныг өөрсдийн үндсэн үйлчилгээнд илүү өргөнөөр ашиглах төлөвтэй байна.

Оксфордын их сургуулийн сүүлийн үеийн судалгаагаар санхүүгийн салбар дахь өсөн нэмэгдэж буй хиймэл оюун ухааны хэрэглээнээс үүдэн АНУ-ын ажлын байрны 47 хувийг ирэх 20 жилийн дотор автоматжуулах тооцоо гарчээ. Түүнчлэн уламжлалт нягтлан бодох болон бүртгэл хөтлөх ажлуудад

нөлөө үзүүлэх магадлал нь 95 хувь байна. Үүний улмаас нягтлан бодогч роботууд анхан болон дунд шатны нягтлан бодох бүртгэлийн ажлуудыг хийж гүйцэтгэх бөгөөд цаашлаад өндөр ур чадвар шаардагдсан ажлуудыг ирээдүйд хийж болзошгүй байна. Үүний үр дүнд Форрестерын тайланд дурдсанаар роботууд болон хиймэл оюун ухаан 2025 он гэхэд АНУ-ын нийт ажлын байрны 7 хүртэлх хувийг орлох урьдчилсан тооцоо гарчээ.


Дүгнэлт, ирээдүйн чиг хандлага

Технологийн хөгжил дэвшил нягтлан бодох бүртгэлийн салбарт шинэ сорилтыг бий болгож, мэргэжилтнүүдийг тасралтгүй мэдлэг, чадвараа дээшлүүлэхийг шаардсаар байна. Хиймэл оюун ухаан нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд аюул учруулж буй шинэ дэвшилтэт технологи бөгөөд анхан болон дунд түвшний нягтлан бодогчдын ажилд хамгийн их нөлөө үзүүлэхээр байна. Хиймэл оюун ухааны улмаас уламжлалт нягтлан бодох бүртгэлийн ажлын байр үгүй болж болзошгүй боловч үүний дүнд ирээдүйн эрэлт шаардлагад нийцсэн шинэ ажлын байрууд бий болох ач холбогдолтой. Ялангуяа зах зээл дээр технологийн өндөр мэдлэгтэй, дүн шинжилгээ хийх чадвар бүхий ажиллах хүчний шаардлага үүсэх нь гарцаагүй юм.

Энэхүү ажлын байрны эрэлтийг хангахын тулд нягтлан бодогчдын хувьд технологи болон түүний шинэ хандлагын талаарх мэдлэг, чадвараа байнга дээшлүүлж, суралцаж байх хэрэгтэй болж байна. Дэлхийн Эдийн Засгийн Форумын төслийн удирдагч Тилл Леополд технологийн улмаас ирээдүйд

нийт шаардагдах ур чадварын 35 хувь нь өөрчлөгдөх болно хэмээн дүгнэсэн байна. Иймд нягтлан бодогчид болон аудитуудыг энэхүү технологийн хувьслын эрин үед амжилттай ажиллахын тулд дараах 8 мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэхийг зөвлөжээ. Үүнд: Ёс зүйтэй шударга байх, тасралтгүй суралцах, харилцаа тогтоож хамтран ажиллах, харилцан ойлголцох, асуудлыг шийдвэрлэх, шинийг санаачлах, багаар ажиллах болон олон ургалч үзэлтэй байх. Хиймэл оюун ухаанд байдаггүй эдгээр хүний онцлог чадваруудаас гадна нягтлан бодогчдын хувьд хиймэл оюун ухаан бүхий систем дээр ажиллаж хамгийн сайн үр дүнг хүртэхийн тулд технологийн мэдлэг чадвараа нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймд дата мэдээнд дүн шинжилгээ хийх болон компьютерийн суралцах чадвар зэрэг сэдвүүдийг нягтлан бодох бүртгэлийн хичээлийн хөтөлбөрт оруулах нь зүйтэй бөгөөд үүний дүнд ирээдүйн нягтлан бодогчдод дата мэдээнд суурилсан орчинд зохицож ажиллах, ажлын байрны зах зээл дээр өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь туслах юм. Үүнтэй холбогдуулан Кэй Пи Эм Жи аудитын компаниас дата мэдээнд дүн шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нягтлан бодох бүртгэлийн магистрын хөтөлбөрийг бизнесийн сургуулиудтай хамтран боловсруулан ажиллаж байна. Иймд дүн шинжилгээ хийх чадвартай нягтлан бодогчид стратегийн шийдвэр гаргах, бизнесийн эрсдэлийг удирдах зэрэгт чухал үүрэгтэй оролцох болно.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 29/IV ӨДРИЙН БАЙДЛААР)**





ДЭЛХИЙН ДАМПУУРСАН БАНКУУДЫН ТҮҮХ

Аливаа банк харилцагчийнхаа авахыг хүссэн мөнгийг анхны хүсэлтээр нь шууд гаргаж өгч чадахгүйд хүрэх буюу төлбөр түргэн гүйцэтгэх чадваргүйд хүрч дампуурдаг. Асуудал хэр том болох нь тухайн банк системдээ нөлөөлөх байдлаас шууд хамаардаг. Тиймээс банкуудыг зуучлал буюу үйл ажиллагааны тархац болон системийн нийт активд эзлэх байр суурийг харгалзан үзэж ямар арга хэмжээ авахыг тодорхойлдог байна.

Банкны үйл ажиллагаа хүндэрч дампуурах нь нийгэм, эдийн засгийн хувьд ихээхэн ярвигтай, иргэд олон нийтийн сэтгэлзүйд сөргөөр нөлөөлөхүйц ноцтой үзэгдэл. Аливаа банкны хадгаламж, харилцах данс эзэмшигчдийн хувьд мөнгөө авч чадахгүй удаашрах нь асуудал мөн. Гэхдээ үүний цаана байдаг бас нэгэн том эрсдэл бол эдийн засгийн хувьд санхүүгийн секторт цусны эргэлт удааширч, улмаар бусад банк, системдээ нөлөөлөх нь бүр том асуудал юм.

АНУ-ын банкны хямрал

Банкны дампуурал ихэвчлэн эдийн засгийн хүндрэлээс үүдэн гарч ирдэг. Дэлхий нийтийг

хамгийн сүүлд нөмөрсөн санхүүгийн хямралыг эхлүүлсэн банкны дампуурлыг юун түрүүнд дурдах нь зүйтэй болов уу. АНУ-ын түүхэнд дампуурсан хамгийн том банк бол Вашингтон Мючуал банк юм. Вашингтон Мючуал нь АНУ-ын хамгийн том хадгаламж, зээлийн үйлчилгээ үзүүлдэг банк байсан ба 2008 онд хямралын "гал авалцах" үед нийт хөрөнгийн хэмжээ нь 307 тэрбум ам.доллар, нийт хадгаламж нь 188 тэрбум ам.долларт хүрээд байв. Тус банк дампуурахад Холбооны хадгаламжийн даатгалын корпораци арга хэмжээ авсан бөгөөд үр дүнд нь Вашингтон Мючуал банкны хөрөнгийг дахин үнэлж JPMorgan Chase банкинд 1.9 тэрбум ам.доллараар зарах зэрэг арга замаар, урт хугацааны үр дүнд иргэдийн хохирлыг барагдуулжээ. Банк хүндэрхэд хүргэсэн хүчин зүйлс нь орон сууцны хямрал, Лейман Бродерсын уналт байсан боловч гол нь тус банкны зээлжих зэрэглэлийг бууруулснаар 9-хөн хоногийн дотор нийт 16.7 тэрбум ам.долларыг харилцагчид нэгэн зэрэг татсанд байгаа юм. Үүнийг "bank run" гэх ба банкыг хурдтайгаар дампууралд хүргэдэг зүйл. Вашингтон

Мючуал нь АНУ-ын 15 мужид 2239 салбартай 43 мянга орчим ажилтантай байсан банк бөгөөд албан ёсоор дампуурлаа 2008 оны 9-р сард зарласан.

АНУ-д 2008-2012 оны хооронд нийт 465 банк дампуурсан байдаг ба 2018 оны 9-р сард Мэйдэн лэйний багцыг борлуулж дууссанаар дампуурсан банкуудын активыг 10 жилийн дараа л бүрэн цэвэрлэсэн байна. Дампуурлаа зарласан банкны харилцагч, хадгаламж эзэмшигчид мөнгөө буцааж авах процесс хэдэн өдрөөс хэдэн сарыг дамждаг. Учир нь татан буугдсан банкны эрх хүлээн авах үед бүх мэдээлэл, санхүүгийн баримт бичиг болон хөрөнгийг бүртгэж авдаг. Энэ үед харилцагчдын мэдээллийг тулгах, шилжүүлэг гүйцэтгэх гэх мэт сунжирсан ажиллагаа нэмэгддэгийг хүмүүс тэр болгон мэддэггүй юм. Банк татан буулгах нь цэвэр хууль эрх зүй дээр үндэслэж хийгддэг бөгөөд хэрэв ямарваа нэг санхүүгийн, хөрөнгийн үнэлгээний, эсвэл бүртгэлийн алдаа гарах юм бол эргээд асуудал гарах эрсдэлтэй тул бүх зүйлийг богино хугацаанд, тодорхой хийнэ гэдэг ихээхэн хүчин чармайлт шаардсан ажил.

Шведийн банк дампуурах шахсан түүх

Олон улсын санхүүгийн хямралын гал бүрэн унтарч амжаагүй үед 2011 оны 12-р сард 1 сая гаруй харилцагчтай Швед банкны тухай худал мэдээлэл твиттер сүлжээнд тарснаар тус банк хүндрэх шахсан байдаг. Швед банк нь Латви улсад 224 салбартай бөгөөд твиттер дээр тус банкы Латви дахь үйл ажиллагаа асуудалд орсон талаар үндэслэлгүй мэдээлэл гарснаар иргэд олон нийт олноороо АТМ машин дээр дараалал үүсгэж мөнгөө татжээ. Улмаар богино хугацаанд 19.2 сая ам.доллар татагдсан бөгөөд Швед банк шуурхай арга хэмжээ авч цуу яриаг таслан зогсоосон байна. Үүнийг дүгнээд үзэхэд твиттерийн 140 тэмдэгийг ашиглаж хэвийн үйл ажиллагаатай банкныг дампууруулж чадах нь байна. Өөрөөр хэлбэл эдийн засаг хүндрээгүй, эрсдэл хуримтлагдаагүй үед ч цуу яриагаар банкныг хүндрүүлж чадах цаг үед бид амьдарч байгаа учраас итгэлцэл дээр тогтдог банкны бизнесийн талаар мэдээлэл тараахдаа тун болгоомжтой хандах нь зохимжтой аж.

Итали Улсын банкны салбарын хямрал

Дэлхийд 8 дугаарт, Европын холбоонд 3 дугаарт орох том эдийн засагтай Итали Улсын банкны салбарт эрсдэл хуримтлагдаад байгааг анхааруулах боллоо. Итали Улс 2019 оны төсвөө ДНБ-ний 2.4 хувьтай дүйцэх хэмжээний алдагдалтай баталж, Европын комисст хүргүүлжээ. Европын холбооны зүгээс тус төсвийг хэт үрэлгэн, Европын холбооны

төсвийн тухай хуулийг зөрчиж байгааг анхааруулж байна. Улмаар өрийн хэмжээ нэмэгдэж, зээлжих зэрэглэл буурснаар банкны салбарт санхүүжилт татахад хүндрэлтэй болоод байгаа аж.

Европын холбооны банкуудад активын чанарын үнэлгээг хийсэн бөгөөд стресс тестийг тогтмол хийж хэвшээд байгаа. Үүний үр дүнд Италийн Кариге банкинд өөрийн хөрөнгөө жилийн хугацаанд 400 сая еврогоор нэмэгдүүлэх даалгаврыг өгсөн ба эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлаас болж биелүүлэхэд удаашрал үүсээд байна. Италид хэмжээгээрээ 10-т орох тус банкны хувьцаа эзэмшигчид урд нь 2 ч удаа гүйцэтгэх удирдлагын багийг өөрчилж, бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх замаар зуу, зуун сая еврогийн хөрөнгө оруулалт хийж, зарцуулсан байгаа. Европын Төв банкны хяналт шалгалтын зүгээс энэ идэвх зүтгэлийг үнэлж гурав дахь удаагаа боломж олгосон.

Итали Улсын эдийн засаг хэдийгээр өндөр хөгжсөн ч гэлээ банкны хямрал үргэлжилсээр байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Италийн гурав дахь том банк Монте Деи Пасчи Сиенаг JPMorgan хөрөнгө оруулалт хийж аварсан бол Венето банк арга хэмжээ авч чадахгүй байсаар төлбөр гүйцэтгэх чадваргүй болж төрийн мэдэлд шилжжээ.

Монгол Улсын банкны салбарт, Капитал банк дампуурсны дараа хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь өмнөх тохиолдлоос өөр болохыг эдийн засагчид онцолж байгаа. Өдгөө хадгаламжийн даатгалын тогтолцоо хөгжиж, хадгаламж

болон харилцах данс эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоо бий болоод байгаа нь нийтийн эрх ашгийг буюу татвар төлөгчдийн мөнгийг эрсдэлд оруулахаас сэргийлж чадах чухал жишиг юм. Монголбанкнаас эрх хүлээн авагч томилж харилцагчдын мөнгийг хуулийн дагуу олгоно гэдгийг мэдэгдээд байгаа учраас цаашид ямар нэг байдлаар энэ үйл ажиллагаанд саад учруулах нь өөрөө нөхөн олговор олгох хугацааг уртасгаж, бүр том эрсдэлийг ч бий болгох магадлалтай тул иргэд олон нийт аль аль талдаа хамтран ажиллах нь чухал.

Эх сурвалж:

<https://www.investopedia.com/slideshow/top-bank-failures/>

<https://www.thestreet.com/story/11342347/1/twitters-first-bank-run.html>

<https://www.bbc.com/news/business-16142000>

<https://www.ft.com/content/889a28e6-08f3-11e9-9fe8-acdb36967cfc>

<https://www.nytimes.com/2018/10/23/world/europe/italy-budget-eu.html?module=inline>



БАНКАА ХЭРХЭН ЗӨВ СОНГОХ ВЭ?

Та мөнгөө банкинд хадгалуулснаар санхүүгийн амжилтанд хүрэх, өөрийн мөнгөндөө илүү сайн хяналт тавих боломжтой. Гэвч мөнгөө найдвартай банкинд хадгалуулах нь хамгийн чухал. Тиймээс аюулгүй, найдвартай банкийг сонгож, үйлчлүүлэхэд тань тус болох зарим зөвлөгөөг хүргэе.

1. БАНКНЫ ҮНЭЛГЭЭНД АНХААРЛАА ХАНДУУЛ

Та заавал санхүүгийн мэргэжилтэн байх албагүй ч олон улсын томоохон байгууллагуудаас тухайн банкны санхүүгийн чадавх, үзүүлэлтүүдийг тогтоосон зэрэглэлийг анхаарах хэрэгтэй. Товчхондоо бол үнэлгээ AAA зэрэг рүү ойртох тусмаа сайн. Энэхүү үнэлгээ нь банкны хариуцлагын хэм хэмжээг харуулахаас гадна эрсдэлийг даван туулах, тэсч үлдэх чадварыг нь давхар батлан харуулж буй юм.

2. ТАНЫ СОНГОСОН БАНК ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИТАЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ УУ?

Хэрэв Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран ажиллаагүй байвал тухайн банкийг сонгож, үнэтэй хөрөнгөө хадгалуулах хэрэггүй л болов уу. Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахын тулд ХДК ажилладаг. Банк таны өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрч, мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар гаргаж өгч чадахгүйд хүрвэл, хадгаламжийн даатгалын корпораци таны хохирлыг барагдуулах ёстой. Монгол Улсын хувьд Хадгаламжийн

даатгалын корпораци нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн 20 сая хүртэлх төгрөгтэй тэнцэх хадгаламж болон харилцахыг хуулийн дагуу бүрэн даатгасан байдаг.

3. БАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ БАЙГААРАЙ

Банкууд жил бүр санхүүгийн тайлангаа өөрийн вэб сайт дээрээ байршуулдаг ч үүнийг уншиж, ойлгоход тийм ч амар биш. Тиймээс Монголбанкнаас тавьж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн хангаж буйг анхаарахад болно. Тухайлбал, банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ 12 хувиас доош байж болохгүй. Мөн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 25 хувиас доошгүй байх нь тухайн банкны найдвартай байдлыг илтгэнэ.

4. БАНКНЫ СИСТЕМД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Хэрэв таны сонгож буй банк нь банк санхүүгийн системд үзүүлэх нөлөө их, хадгаламжийн зах зээлд ихэнх хувийг эзэлдэг бол ямар нэгэн хүндрэл гарахад түүнийг заавал аварч үлдэх магадлал өндөр болно. Аврахгүй тохиолдолд банк санхүүгийн систем нуран унах юм.

5. ХАДГАЛАМЖИЙН ХҮҮГИЙН ТҮВШИНД АНХААРЛАА ХАНДУУЛААРАЙ

Хамгийн өндөр хүү амлаж байгаа банк мөнгө татан байршуулах маш их сонирхолтой байна гэсэн үг юм. Таны хөрөнгийг өндөр хүү амлаж байршуулаад,

найдвартай зээлдэгчдэд олгож байвал тийм ч том асуудал биш. Харин “буруу гарын” этгээдэд хэт ихээр зээлдүүлэх, банкны эзэд өөрсдийн бизнестээ зүй бусаар зарцуулаад эхэлбэл, таны мөнгөн хөрөнгийн найдвартай, баталгаатай байдал тэр хэмжээгээр алдагдах нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй. Ерөнхийдөө зах зээлийн дундаж хүүгийн түвшнээс хэт өндөр хүү амлаж байгаа бол түүний цаана ямар нэгэн эрсдэл нуугдаж байхыг үгүйсгэх аргагүй юм.

6. ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ



Банкны жинхэнэ эзэд нь хэн байна вэ гэдгийг судлахад илүүдэхгүй шүү. Банкны удирдлагууд харилцагчдад хангалттай цаг зарцуулж, ил байдаг бол энэ нь банкинд ямар нэгэн асуудал тулгарсан үед удирдлагууд өөрийн нэр хүндийг дэнчин тавьж чадна гэсэн үг.

7. МЭДЭЭЛЛИЙН СУВАГ

Олон банкны ажилтнуудтай харилцаж, найз болоорой. Ингэснээр банкны дотор юу болж буйг мэдэх боломжтой.



8. ХҮРТЭЭМЖ

Өөрийн хэрэгцээндээ тохируулан хангалттай олон салбар, тооцооны төв, АТМ машин, цахим үйлчилгээ, интернэт банк болон 24 цагийн үйлчилгээний зөвлөх ажилладаг банкиг сонгоорой.



9. БҮХ МӨНГӨӨ НЭГ САГСАНД БҮҮ ХИЙ


Та их мөнгө хадгалуулахаар бол олон банканд мөнгөө хадгалах нь илүү аюулгүй байдаг. Мөн зөвхөн нэг банкны үйлчилгээг ашиглахыг хүсч байгаа хэдий ч тухайн банкны үйлчилгээ нь нэг эсвэл хоёр өдрийн турш тасалдах нь танд томоохон хүндрэл учруулна. Иймд та бүх мөнгөө нэг сагсанд хийхийн оронд тараан байрлуулах нь илүү оновчтой юм.



ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2019/04/30-ний хооронд 1,074,9 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1079 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.

График 1. 2000-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



ГУРАВДУГААР САРД 91 КГ АЛТ ХУДАЛДАН АВЛАА

График 1. Монголбанкны алт худалдан авалтын сарын мэдээ /2018-2019 он/



Монголбанк 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд 1.6 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 3.1 тонн алт худалдан авсанаас 1.5 тонн дутуу буюу 48% буурсан үзүүлэлттэй байна.


Монголбанкны алт худалдан авалт ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсоноос хойш /АМНАТ 5% болсноос хойш/ буюу 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөс

2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хугацаанд 837 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 753 кг алт худалдан авснаас 84 кг-аар их буюу 11%-иар өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны 1 сараас 2019 оны 4 сарын 25-ны өдрийг хүртэл Монголбанкны алт худалдан авалтын сарын мэдээг дараах график 1-т үзүүлээ.

1990 оноос 2019 оны 4 сарын 25-ны өдрийг хүртэл Монголбанкны алт худалдан авалтын жилийн мэдээг дараах график 2-т үзүүлээ.

График 2. Монголбанкны алт худалдан авалтын жилийн мэдээ /1990-2019 он/



“Хүн нэг өмөө босоод л
санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)




ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч,
хадгалагч, зээл тооцоологч, ипотека, төсөвлөгч зэрэг
тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn



 /Mongolbank.mn

 /Санхүүгийн боловсрол

 @mongolbank_mn

 www.mongolbank.mn

 /Mongolbankmn

 info@mongolbank.mn

 11 310081